# НИЙГМИЙН УХААНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА



# НИЙГМИЙН УХААНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА

ННА 60
ДАА 300
М - 816

© Г.Мөнх-Эрдэнэ, Ариел Ахэрн, 2022

Хянагч: Б.Бумбаяр
Орчуулагч: У.Дарьбум
Хавтасны зургийг: П.Чулуунбат

Монголын Антропологийн Холбооны
"Антропологийн үндсэн ойлголт" цуврал

Цаасны хэмжээ: А5
Хэвлэлийн хуудас: 7хх
ISBN: 978-9919-27-986-8

# АГУУЛГА

Өмнөх үг ........ 4

Багш нарын товч танилцуулга........ 7

**БҮЛЭГ 1:**

Нийгмийн ухааны судалгаа, философи, онолын удиртгал ........ 9

**БҮЛЭГ 2:**

Эрдэм шинжилгээний бүтээл гэж юу вэ? ........ 17

**БҮЛЭГ 3:**

Судалгааны сэдэв сонгох ........ 27

**БҮЛЭГ 4:**

Судалгааны арга зүйгээ сонгох ........ 35

**БҮЛЭГ 5:**

Яагаад судалгааны ёс зүй хамгийн чухал вэ? ........ 43

**БҮЛЭГ 6:**

Судалгааны аргумент боловсруулах ........ 49

**БҮЛЭГ 7:**

Эшлэл авах, ном зүй хийх,
оюуны бүтээлийн эрх зөрчихгүй байх........ 55

**БҮЛЭГ 8:**

Чанарын мэдээллийг задлан шинжлэх нь........ 61

**БҮЛЭГ 9:**

Эрдэм шинжилгээний бичвэр ямар байх ёстой вэ? ........ 67

**БҮЛЭГ 10:**

Эрдэм шинжилгээний бичвэрийн бүтэц ........ 73

**БҮЛЭГ 11:**

Судалгаагаа хэвлүүлэх сэтгүүлээ яаж сонгох вэ? ........ 79

**БҮЛЭГ 12:**

Мэргэжлийн судлаачийн СиВи бичих ........ 85

**БҮЛЭГ 13:**

Японы академик тогтолцоо ........ 91

**БҮЛЭГ 14:**

Монголын тухай судалгаа ........ 97

Ном зүй ........ 107

## Өмнөх үг

Их Британийн Эдийн засаг, нийгмийн судалгааны зөвлөл (ESRC) болон Япон улсын Шинжлэх ухаан дэмжих нийгэмлэгийн (JSPS) хамтран санхүүжүүлж буй "Ковид-19-ийн дараах Дотоод Азийн малчин нийгмийн харьцуулсан судалгаа" (Comparative Research on Pastoral Societies in Post-Covid 19 Inner Asian Countries) төслийн хүрээнд уг гарын авлага хэвлэгдэж байна. Тус судалгааны төслийн хүрээнд Окфордын их сургууль, МУИС, Японы Кагошима, Мэйжи, Кобэ, Сайтама, Ракуно Гакуен, Токиогийн гадаад судлалын сургууль, Киргизстаны Төв Азийн их сургууль зэрэг дөрвөн улсын есөн сургуулийн арав гаруй судлаач 2022-2025 оны хооронд Монгол, Киргизстан улсад хамтарсан хээрийн судалгаа хийж, антропологийн эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэхээс гадна залуу судлаачийг чадавхжуулах сургалт зохион байгуулах юм. Энэхүү ажлын эхлэл болгон судалгааны баг 2022 оны VIII сарын 18-21-ний өдрүүдэд МУИС-ийн Номын санд монголын залуу судлаач, оюутанд зориулан "Нийгмийн ухааны чанарын судалгаа" нэртэй Зуны сургалт зохион байгуулав. Тус сургалтад ашигласан эх хэрэглэгдэхүүн болон сэдэвтэй холбоотой Оксфордын их сургуульд заадаг зарим агуулгыг багтаасан уг гарын авлага нь нийгмийн ухааны судалгаа хийхийг хүсдэг, судалгааныхаа чанарыг сайжруулахыг зорьж буй хэн бүхэнд хэрэг болох биз ээ.

Та бидний гарын авлагыг унших, ашиглахдаа Youtube-ийн Post-Pandemic Inner Asia Project нэртэй суваг руу орж (https://www.youtube.com/channel/UCZkndnOl7D3tPg21wIbwecA/videos), дурдан буй зуны сургалтын үеэр бичсэн видео бичлэгийг давхар үзэж сонирхоорой. Гарын авлагын бүлэг бүрийн дагуу нэрлэсэн бичлэгийг давхар үзэж сонсон, бичвэрээ харгуулан уншвал сэдэв тус бүрийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч, тухайн үед ямар агуулга, контекст өрнөж байсныг мэдэх давуу талтай болов уу.

Бидний урилгыг найрсагаар хүлээн авч Зуны сургалтанд маань хичээл заасан Нүүдлийн Соёл Иргэншлийн Судлах Олон Улсын Хүрээлэнгийн захирал И.Бямбабаатар, Канадын Виннипег их сургуулийн багш Эрик Трифт нар баярлалаа. Сургалтын зохион байгуулалтын ажилд хүчин зүтгэсэн НСИСОУХүрээлэнгийн ажилчид, тэр дундаа хичээлийн агуулгыг видео бичлэгт буулгаж,

Youtube-д байршуулахад бэлэн болгосон Г.Зулбаатар, Б.Бумбаяр хоёрт талархлаа. Мөн англи хэлнээс монгол хэл рүү орчуулах ярвигтай ажлыг нугалалцсан У.Дарьбум, Э.Золжаргал нартаа баярлалаа.

Гарын авлагын хавтсыг чимсэн чулуун арслангийн хөшөөний зураг санамсаргүй сонголт биш юм. Өнгөрсөн буюу 2022 оны VII, VIII сард Ариел Ахэрн бид хоёр Баянхонгор аймгийн Баацагаан, Өлзийт болон аймгийн төвөөр хээрийн судалгаа хийж явах үедээ аймгийн музейн урд талд байх уг хөшөөний тухай санамсаргүй яриа дэлгэж таарсан юм. Тухайн үед бид хоёр удахгүй зохион байгуулах Зуны сургалтынхаа талаар ярилцахын зэрэгцээ монголын нийгмийн ухааны судалгааны чанарыг шүүн тунгааж, алдаа оноог нь хэлэлцэж байв. Үнэндээ манай зарим судалгаа уг арслангийн хөшөө шиг нэг зүйлийг сонгож аваад, түүний өндөр, өргөн, хаанаас олдсон, юугаар хийсэн гэх мэтийг бичсээр байгаагаа эрдэм шинжилгээний судалгаа гэж нэрлэн хэвлүүлсээр байдаг билээ. Энэ байдлын хамгийн гол дутагдал нь өнөөх л бидний амны уншлага болсон "шүүмжит сэтгэлгээ" дутмаг, тоочсон, дүрсэлсэн шинж чанар бөгөөд энэ зуршил манай судлаачид судалгаагаа олон улсын сайн сэтгүүлд хэвлүүлэхэд хамгийн том тээг саад болж байгаа юм.

Зуны сургалтын үеэр Ариел тэрхүү чулуун арслангийн хөшөө шиг сэдэв сонгож, судалгаа хийх нь эрдэм шинжилгээний үүднээс сонирхолгүй, судлаачид бүтээлийг чинь уншихгүй, эшлэхгүй эргээд та "сайн" судлаач болохгүй байх аюултайг сануулж байв. Үлдсэн өдрүүдэд ч гэсэн сургагч багш нар төдийгүй сургалтад хамрагдагсад өнөөх "чулуун арслангийн хөшөөгөөр" ямар нэгэн асуудал шийдэхгүй, сонирхолгүй, эрдэм шинжилгээний гэхээсээ илүү хувь хүний сонирхол болсон, мэргэжлийн хэлэлцүүлэг, онол, арга зүйгээс хол хөндий сонирхогчийн шинжтэй судалгааны сэдэв, арга зүй, онол тайлбар зэргийг хочлон нэрлэх болсон юм. Өөрөөр хэлбэл, сургалтад хамрагдсан хүн бүр "чулуун арслангийн хөшөө" гэдэг юуны жишээ вэ гэдгийг ойлгож, инээлддэг болчихсон гэсэн үг.

Тиймээс л "чулуун арслангийн хөшөө" шиг сэдэв сонгож, судалгаа хийж болохгүй шүү гэдгийг хавтасны зургаар дахин дахин сануулж буй юм. Нэгэнтээ та цаг зав, эрч хүч, залуу нас, хөрөнгө мөнгө гээд хамаг зүйлээ зарцуулан судалгаа хийж байгаа юм чинь

хэрэгтэй судалгаа хийх учиртай болов уу. Тэрхүү судалгаа тань монголын нийгмийн аль нэг асуудлыг шийдсэн эсвэл ямар нэгэн бүтээлч, шинэлэг мэдлэг бүтээсэн сэдэв байх хэрэгтэй болов уу. Хэрвээ та сайн судалгаа хийж, түүнийгээ мэргэжлийн сайн сэтгүүлд хэвлүүлэхийг хүсдэг бол уг гарын авлага дээр бичсэн зүйлсийг дарааллын дагуу хийгээд явахад хүссэндээ лавтай хүрнэ хэмээн амлах байна. Танд амжилт хүсье.

*МУИС-ийн Антропологи, археологийн тэнхимийн*
*Ахлах багш Г.Мөнх-Эрдэнэ*
*2022.X*

## Багш нарын товч танилцуулга

**Гантулгын Мөнх-Эрдэнэ** нь МУИС-ийн Антропологи, археологийн тэнхимийн ахлах багш, МУИС-д антропологи, Мэлбөрний их сургуульд хөгжил судлалын чиглэлээр суралцсан. Тэрээр ШУТИС-д багш, Австрийн шинжлэх ухааны академи, Копенхагэний, Кэмбрижийн, Нью Йорк их сургуулиудад зочин судлаачаар ажиллаж байсан бөгөөд Монгол дахь капитализм, хөгжил, соёлын өв, уул уурхай, малчдын нийгмийн асуудлыг сонирхон судалдаг.

**Ариелл Ахэрн** нь Оксфордын их сургуулийн Газар зүй, хүрээлэн буй орчны сургуулийн багш. Монголын хөдөөгийн соёлын үнэ цэн, нийгмийн харилцаа, ажил хөдөлмөрийн өөрчлөлт зэргийг судалдаг судлаач юм. Мөн тэрээр өөрчлөгдөж буй эдийн засаг, улс төрийн дэглэмийн холбоо хамаарал болон нийгмийн харилцаа, ёс суртахуун, үнэ цэний ойлголтод тэрхүү өөрчлөлт яаж нөлөөлж байгааг судалдаг. Тэрээр Монголын хотууд орчмын болон хөдөөгийн амьдралыг угсаатны зүйн аргаар судалж байгаа билээ.

**Такахиро Озаки** нь Японы Кагошима их сургуулийн профессор, нийгэм-соёлын антропологич. Монголын тухай сүүлийн хорь гаруй жил судалж, зуд-байгалийн гамшиг, малчдын амьдрал, соёлын аялал жуулчлалын тухай олон судалгаа хэвлүүлжээ.

**Трой Стернберг** нь Оксфордын их сургуулийн газар зүйч, хуурай уур амьсгалтай газрын байгаль орчин, нийгмийн асуудлаар мэргэшсэн судлаач юм. Тэрээр аялах нь хүмүүний ертөнцийг ойлгоход их чухал гэж үздэг учраас амьдралынхаа ихэнх хугацааг Монгол, Төв Азийн бүс нутгийг судлан өнгөрүүлжээ.

**Бөхөө Хошино** нь Японы Ракуно Гакуен их сургуулийн профессор. Монголын амьтан, хүрээлэн буй орчин, ус, цаг агаарын тухай судалгаа хийдэг.

**Такахиро Томита** нь Японы Кобэ их сургуулийн багш, нийгэм-соёлын антропологич. Монголын малчдын амьдрал, хүн, хүрээлэн буй орчны харилцаа, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байсан туршлага, байгалийн баялгийн ашиглалт зэрэг сэдвээр судалгаа хийдэг.

**Мое Терао** нь Японы Кагошима их сургуулийн судлаач, нийгэм-соёлын антропологич. Монголын зочлох ёс, нүүдэл, цагаан идээ тухай судалгаа хийдэг.

**Юүко Мацумияа** нь Японы Сайтама их сургуулийн багш. Нийгмийн газар зүйч. Монголын малчдын амьдрал, Улаанбаатар хотын гэр хороолол, шилжих хөдөлгөөний тухай судалгаа хийдэг.

**Ичинхорлоогийн Бямбабаатар** нь Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал. Өмнө нь тэрээр Цюрихийн их сургуульд багш, Кэмбрижийн, Буюлдер дахь Колорадогийн, Лондон Коллеж, Портогийн их сургуулиудад зочин судлаачаар ажиллаж байв. Мөн тэрээр антропологийн ухааны доктор, хэл шинжлэлийн ухааны магистрын зэрэгтэй, хөгжлийн хөндлөнгийн оролцоо, нүүдлийн соёл, эдийн засгийн олон янзын байдал, уул уурхай, улс төрийн экологи, мал аж ахуй зэрэг өргөн хүрээтэй судалгаа хийдэг судлаач юм.

**Эрик Трифт** нь Канадын Виннипег их сургуулийн багш, нийгэм-соёлын антропологич. Монгол дахь нийгэм-экологийн харилцаа, хүрээлэн буй орчин, соёлын янз байдлын тухай судалгаа хийдэг.

# БҮЛЭГ 1:

## НИЙГМИЙН УХААНЫ СУДАЛГАА, ФИЛОСОФИ, ОНОЛЫН УДИРТГАЛ

АРИЕЛ
АХЭРН

## Хичээлийн тухай

Энэхүү хэсэгт нийгмийн шинжлэх ухааны судалгааны философи үндэслэл, үндэс суурийн тухай заах юм. Аливаа зүйлийг судална гэдэг мэдлэг бүтээх нэгэн хэлбэр юм. Ингэж үзвэл судалгаа нь мэдлэг бүтээх бусад хэлбэрээс ямар ялгаатай болох тухай тайлбарлах шаардлага үүснэ. Мөн уг хэсэгт онтологи, эпистемологи хэмээх ойлголтын талаар болон нийгмийн шинжлэх ухааны судалгааны нийтлэг загваруудыг танилцуулах юм. Тус хичээлээр бид философийн үзэл санаа, онол, судалгааны зорилгыг тодорхойлоход, мөн судалгааны үр дүнг танилцуулахад ямар чухал үүрэгтэй болох талаар голлон үзнэ. Түүнчлэн эмпирик судалгааны хүрээнд авч үзэх боломжтой асуултад, түүний хэмжээ хязгаарт онол, үзэл баримтлал (өөрөөр хэлбэл, судалгааны загвар) ямар үүрэгтэй байдаг талаар хэлэлцэнэ. Эцэст нь бид байгууллага, мэдлэг болоод хүч-эрх мэдэл хоорондын харилцан холбоо, мөн нийгмийн шинжлэх ухааны мэдлэгийг колоничлолоос салгах үйл явцын талаар ярилцаж, санал солилцоно.

## Судалгааны философи, онолын удиртгал

Судалгаа гэж юу вэ? Зарим судлаачийнхаар бол "Мэдлэгийг дэг журам, цэгцтэйгээр эрэлхийлэх" (Smith & Glass 1987), эсвэл "судалгааны асуудлыг улам урагшлуулж, асуудалд хариу болох баримтыг танилцуулдаг" (Creswell 1994), бүүр эсвэл "Нийгмийн судалгаа нь асуултад хариу олох гэсэн арга зам юм" (Clark et al., 2021, 5) гэсэн олон тодорхойлолт байна. Энэ бүхнээс үзэхэд судалгаа заавал мэдлэг бүтээх ёстой болж таарах нь. Тэр дундаа шинэ мэдлэг бүтээх, судалгааны ямар нэгэн асуудлыг шийдэх гэсэн хандлагатай байх учиртай нь тодорч байна. Түүнээс бус ямар нэгэн зүйлийн өндөр намыг тодорхойлж бичсэн эсвэл тэр бүр хүн, уншигч сонирхохгүй сэдвийг судлах нь тэр бүр судалгаа гэсэн ангилалд орохгүй болж таарлаа. Энэ бүхнээс гадна эрдэм шинжилгээний судалгаа гэдэг нийгмийн асуудалд идэвхтэй оролцдог байхыг шаардана. Ингэж оролцохдоо аливаа улс төр зэрэг аль нэг ашиг сонирхлоос ангид байх ёстой. Аль нэг намын, эрх мэдэлтний, нийгмийн бүлгийн эсвэл хэн нэгний ашиг сонирхлыг илэрхийлж, түүнд үйлчилж байвал эрдэм шинжилгээний судалгаа гэж үзэхэд хэцүү юм.

Тэгвэл аливаа зүйлийг яаж судлах вэ? Нэн тэргүүнээ судалгааны асуулт, асуудал зэргээ тодорхойлох хэрэгтэй. Судалгааны тодорхой төлөвлөгөө гаргаж, ёс зүй, арга зүйгээ сонгож, түүнийгээ чанд мөрдөх учиртай. Мэдээж сонгосон судалгааныхаа аргаар мэдээлэл цуглуулах, түүнийгээ дүгнэн шинжлэх шаардлагатай. Ингэхдээ тухайн мэдээллээ тайлбарлаж шинжлэх судалгааны үзэл баримтлал ямар байх нь тодорхой байх хэрэгтэй. Ингэж байж л өмнө дурдсан тодорхойлолт шиг ямар нэгэн судалгааны асуултад хариулсан, шийдэл санал болгосон, судалгааны ололт нээлттэй, шинэ мэдлэг бүтээсэн үр дүн гарна гэсэн үг.

Дараагийн анхаарах зүйл бол “тэнцвэрээ барих” явдал юм. Судалгааны асуулт, арга зүй, мэдээлэл, аргумент зэргээ тэнцвэржүүлэх, уялдуулах шаардлагатай. Судалгааны асуудлаасаа зөрсөн мэдээлэл цуглуулах, огт өөр аргумент дэвшүүлэх зэрэг нь таны судалгааг ямар ч зохион байгуулалт, учир зүйн холбоосыг дагаагүйг харуулах төдийгүй судалгаа мөн үү гэсэн асуудалд ч хөтөлж мэднэ. Тиймээс та өөрийн судалгаандаа сонгосон арга зүй, арга барилаа яагаад сонгосон, яагаад энэ арга зүй судалгаанд чинь тохироод байгааг сайтар тайлбарлаж, түүнийгээ эцсийн үр дүнтэйгээ учир зүйн уялдаатайгаар холбон, тэнцвэржүүлэх хэрэгтэй.

Зөвхөн ямар нэгэн судалгааны сэдэв сонгох, судалгааны асуулт боловсруулах, арга зүй сонгоод та судалгаа хийчихгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Та сайн судалгаа хийх, судлаач байхад нийгмийн харилцаанд идэвхтэй оролцдог, нийгэмд хэлэлцэгдэж буй өдөр тутмын мэдээллээс хоцроогүй байх хэрэгтэй болдог. Түүнчлэн судалгаа амжилттай болоход судалгааны мөнгө санхүүжилт, түүнийг гаргах байгууллага зэрэг өөр бусад талтай ч холбоотой ажиллах шаардлага тулгарна. Энэ мэт судалгааны ажлыг дэмждэг байгууллага нь тусгай хууль, дүрэм, журмаар зохицуулагддаг томоохон газрууд байдаг. Жишээ нь, Их Британийн засгийн газар Оксфордын их сургуулийн вакцины технологийн багийг 2016 оноос хойш дэмжиж ирсэн бөгөөд 2020 оны 3 дугаар сараас хойш Ковид-19 ийн эсрэг вакцины судалгаа, хөгжүүлэлт, үйлдвэрлэлд 88 сая паунд зарцуулаад байна.

## Судалгааны загвар

Судалгааны загвар, хэв маягаа сонгохдоо өмнө дурдсан мэдлэг гэж юу вэ? гэх асуултаа байнга бодож байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, та судалгаа хийхдээ олон төрлийн мэдээлэл, өгөгдөл цуглуулах бөгөөд түүнийхээ алийг нь үнэ цэнтэй, хэрэгтэй гэж үзэх, тооцох тэрхүү мэдлэг хэний дуу хоолой, үзэл бодол, сонирхлыг илэрхийлж байгааг тунгаах хэрэгтэй болно.

Таны судалгааг дан ганц таны судалгаа юу эсвэл аль нэг баг хамт олон, байгууллагын судалгаа юу гэдгээс хамаарч судалгааны загвар, хэв маяг тань урган гарна. Кресвэллийн (2009) бичсэнээр судалгааны загвар дараах гурван элементээс бүрдэх ёстой ажээ. Тэдгээр нь:




- Философийн элемент
- Судалгааны стратеги
- Судалгааны үйл явц зэрэг юм.

Философийн элемент гэдэг нь ямар онол баримтлах тухай асуудал бол судалгааны стратеги гэдэгт чанарын, тоон эсвэл холимог судалгааны арга ашиглахыг хамааруулна. Харин судалгааны үйл явц гэдэгт судалгааны эхнээс төгсгөл хүртэлх үйл явцыг хэлж байна.

Мөн зарим судлаачийнхаар "судалгааны арга ашиглан олсон мэдээллийг задлан шинжлэхэд чиглэсэн бүтцийг" (Кларк болон бусад 2021, 39) судалгааны загвар гэж болох гэнэ. Ингэхлээр судалгааны аргаа судалгааны загвартайгаа хольж хутган ойлгох хэрэггүй гэсэн үг. Учир нь, шинжлэх ухааны салбар бүрийн онцлогоос болж судалгааны арга, загвар өөр өөр байдаг билээ.

Судалгааны загварын хэд хэдэн төрөл байж болно. Философийн эсвэл онолын үүднээс аливааг яаж харах ойлгохоо тогтохоос эдгээр загварын ялгаа гарна. Жишээ нь, бодит байдал эсвэл мэдлэг гэж юу вэ? гэдгийг яаж ойлгохоос болно гэсэн үг. Бидний сайн мэдэх Онтологи буюу ахуйн тухай сургаал гэж орчуулдаг философийн салбарын үүднээс бол бодит байдал юунаас бүрддэг вэ, ертөнцийн мөн чанар юу вэ, юмс үзэгдэл бидний төсөөллөөс хамааралгүйгээр оршдог уу, нийгмийн бодит байдлыг нийгмийн оролцогчид бүтээдэг үү, эсвэл тэднээс ангид оршдог уу гэх мэт олон чухал асуудлыг хөнддөг. Та энэхүү асуудлыг яаж ойлгож байгаагаас судалгааны тань асуулт урган гарна.

Эпистемологи буюу мэдлэгийн тухай онол гэж орчуулдаг салбарын үүднээс бидний мэдлэг гэж үзээд байгаа зүйл юу болохыг ойлгож болно. Жишээ нь, ямар төрлийн мэдлэгийг судлаачид хүлээн зөвшөөрч судалгаандаа ашиглаж байна вэ, аливаа зүйлийн талаар мэдлэгийг бид яаж олж авдаг вэ, ямар төрлийн мэдлэг үнэ цэнтэй, "үнэн зөвд" тооцогдох вэ гэх мэт асуултыг асуухаар өөр аргагүй. Өөрөөр хэлбэл, бид судалгаа хийхдээ энэ мэт маш олон ээдрээтэй асуудлыг дунд орчихдог төдийгүй тэр бүхэнд яаж хариулж байгаагаас бидний судалгаа хамаардаг гэсэн үг. Эпистемологийн жишээ болсон доорх хоёр хандлагыг харцгаая. А). Хүн ертөнцийг объектив ажиглалт, хэмжилтээр дамжуулан таньж чадна. Хүний оюун ухаан ертөнцөөс тусдаа оршдог. Б). Бид хэл, соёлоор дамжуулан суралцдаг; мэдлэг нь нийгмийн үйл явцад үргэлж шингэсэн байдаг. Тиймээс мэдлэг хэзээ ч жинхэнэ объектив байдаггүй.

### Судалгааны парадигм

"Мэдлэг, бидний нийгмийн амьдрал, бидний ертөнцийг мэдэх чадвар хийгээд шалтгааны тухай философийн таамаг бүхий цогц зүйлийг парадигм гэнэ" (Lincoln & Guba, 1985; Patton, 2003).

Нийгмийн ухаанд онолын үзэл баримтлал олон бий. Хамгийн түгээмэл бидний мэдэх онол, хандлага гэвэл: Позитвизм ба орон зайн шинжлэх ухаан, Хуманизм ба Феноменологи, Марксист онол, Феминист онол, Хуман онол, Постструктурализм ба төлөөллийн бус онолууд, Постколониализм, Постмодернизм зэргийг нэрлэж болно.

Гэвч эдгээр бүх онолд Барууны соёл хүчтэй нөлөөлсөн байдгийг мартаж болохгүй. Эртний Грекийн гүн ухааны нөлөө, Сократ, Платон, Аристотелийн бүтээл, өмнө дурдсан Онтологи, Эпистемологийн судалгаа зэрэг олон нөлөө бий. Тиймээс ч өнөө цагт Барууны нөлөө мэдлэг, онол, гүн ухааны салбарт ноёрхож байгааг олон судлаач шүүмжлэх боллоо. Учир нь, Барууны нөлөөтэй шинжлэх ухаан нь анхлан хөгжихдөө ховор эд зүйлс, амьтан ургамал зэргийг цуглуулан, түүнийгээ бусдад үзүүлэх зорилгоор үзүүлэн дэглэсэн өрөө хийх. Тэрхүү цуглуулга нь эзнийхээ нийгмийн статус, хөрөнгө баялгийг харуулах зорилготой байв. Тиймээс ч элитүүд мэдлэгийг хадгалагчид болдог. Тэд мэдлэгийг цэгцлэн “орон зайн дэгт” (Vogel 2015) оруулдаг, “мэдлэг, оюуны театр” (Morus 2017, 157) гэж үзэгддэг байв. Улмаар энэ мэт томоохон цуглуулгууд нь анхны олон нийтийн музейн эхлэл болсон (жишээ нь, Оксфордын музей) байдаг.

Үүний дараагаар буюу Соён гэгээрлийн үе өнөөх цуглуулгуудаа эзэмшигчид нь юм уу эсвэл “судлаачид” цэгцэлж, ангилж цэгцтэй болгох болсон төдийгүй байгаль ертөнц нийтлэг нэгэн хуульд захирагддаг гэж үзэх хандлага дэлгэрчээ. Тиймээс ч хүний нийгмийн захирдаг байгалийн хууль шиг нэг хууль бий гэж үзэн, нийгмийн тухай судалгааг байгаль/физикийн судалгаанд суурилж хийх чиглэл ихэд дэлгэрсэн байдаг.

Одоо доорх зургийг хараад өгөгдсөн асуултын дагуу шууд болон шууд бус арга замаар ажигласан зүйлээ өгөгдсөн хүснэгт дэх зааврын дагуу бичицгээе.



- Энэ зургийг ямар ямар байдлаар тайлбарлаж болох вэ?
- Зургийг тайлбарлахад ямар хүндрэл гарав?
- Зургийг ямар өнцгөөс тайлбарлав?
- Энэ дасгал шинжлэх ухааны судалгааны тухай юуг сургав?

| | Cogitative Domain (оюун ухаан, сэтгэхүй) | Affective Domain (мэдрэмж, сэтгэл хөдлөл) |
|---|---|---|
| Шууд ажиглалт | Шууд ажиглаж буй объект, түүний шинжүүд | Төрсөн сэтгэгдэл, хандлага |
| Шууд бус ажиглалт | Мэдлэгийн бүтцэд суурилсан тайлбар | Нийгэм соёлоос хамааран бий болж буй хандлага, бэлгэдэл, тайлбар |

**Сэдэвтэй холбоотой унших бүтээл**

Shaw, I.G.R, Dixon, D.P., and J.P. Jones III. 2010. Chapter 2: Theorizing our World. In Research Methods in Geography: A critical introduction. John Wiley and Sons.

Aitken, S. and Valentine, G. 2006. 'Ways of knowing and ways of doing geographic research', in Approaches to Human Geography, Sage, London.

Allen, J. 2006. ‘A question of language’, in Pryke, M. et al. (eds.) Using Social Theory, Sage.

Brown, M.E., Duecas, A.N. 2020. A Medical Science Educator’s Guide to Selecting a Research Paradigm: Building a Basis for Better Research. Med.Sci.Educ. 30, 545–553.

Blaikie, N. 2000. ‘Chapters 1, 2 and 3’, in Designing Social Research, Wiley-Blackwell

Clark, N. 2003. ‘The play of the world’, in Pryke et al. (eds.) Using Social Theory: Thinking Through Research, Sage.

Creswell, J.W. 2009. Research Design: Qualitative, Quantitative and Mixed Method Approaches, Sage, London.

Crotty, M. 1998. The Foundations of Social Research, Sage.

Flowerdew, R. 2009. ‘Scientific method’, in Kitchin, R. and Thrift, N. (eds.) Encyclopaedia of Human Geography, Elsevier, Oxford.

Gilbert, N. 2008. ‘Conceptualising social life’, in Researching Social Life, Sage, London.

Hollis, M. 1994. The Philosophy of Social Science, An Introduction, Cambridge: Cambridge University .

Law, J. (2013) ‘Notes on fish, ponds and theory’. https://sv.uio.no/sai/english/research/projects/newcomers/ publications/working-papers- web/law-notes-on-fish-ponds-and-theory.pdf

May, T. (1997) Social research: issues, methods and process, Open University Press.

Nagel, J. (2014) Knowledge: A very short introduction. Oxford University Press

# БҮЛЭГ 2:

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

ТРОЙ
СТЕРНБЕРГ

## Хичээлийн тухай

Судалгааны ном зохиол нийгэмд шинэ мэдлэг хүргэх чухал үүрэгтэй. Эрдэм шинжилгээний зохиол бүтээл бичсэнээр баримт нотолгоотой, бусад эрдэмтдээр хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг, мэдээллийг түгээдэг. Судлаачид зохиол бүтээл бичих нь өөрсдийн хийсэн ажиглалт, судалгаа, олж илрүүлсэн нээлтээ бусад эрдэмтэн мэргэжилтнүүд болон олон нийттэй хуваалцах үр дүнтэй арга юм. Эрдэм шинжилгээний бичвэр бүтээл нь түүх хүүрнэл бус, мэдлэг мэдээлэл өгөх зорилготой тул маш ойлгомжтой, нарийн, тодорхой байх шаардлагатай. Судлаачид бид өөрсдийн зохиол бүтээлээ бусдад таниулах, ойлгуулахыг зорьдог билээ. Бид судалгаагаа түмэнд түгээх хамгийн үр дүнтэй арга бол судалгааны ном зохиол бичих юм.

## Эрдэм шинжилгээний ном зохиол

Шинэ санаа, мэдээлэл, шинэ баримт, концепц, арга зүй, онол, тайлбартай бичвэрийг эрдэм шинжилгээний гэж хэлж болно. Тэрхүү бичигдсэн зүйл нь дахин шалгаж, сорьж, ажиглаж, шинжлэхэд нээлттэй, боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн судалгаа, туршилтыг бусад хүн давтан хийхэд ижил үр дүн гарах ёстой гэсэн үг. Хэрэв тийм биш бол няцаагдана. Мөн уг судалгаа хэвлэгдэхийн тулд тухайн судалгааны салбарын 2-7 мэргэжилтнээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байх ёстой. Тиймээс эрдэм шинжилгээний ажил нь тодорхой сэдвээр нарийн мэдээлэл өгдөг, нэг үндсэн санаанд тулгуурлан, нэг зүйлээ олон давтахгүй, сэдвээс хазайгаагүй байх ёстой болно. Бичвэрийн хэсэг бүр нь гол санааг бататгах аргумент, мэдээлэл агуулж, үнэн зөв, оновчтой үгсийг сонгон бичсэн байвал сайн.

**Судалгааны өгүүллийг** тухайн салбарт мэргэшсэн судлаачид бичдэг. Өгүүлэлд салбарын бусад мэргэжилтэн хөндлөнгийн үнэлгээ өгч, хянана. Бичлэгийн хэлбэр нь албан; тухайн салбарт нийтлэг хэрэглэгддэг үг, хэллэгийг ашиглана. Ашигласан материалын жагсаалтын заавал хавсаргана. **Шинжлэх ухааны ном зохиол** гэж байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны салбарт хийсэн онолын судалгааны ажлыг нийтлэн хэвлэсэн хэлнэ. Судалгааны бүтээлийг хэвлэн нийтэлснээр судлаачийн хийсэн судалгааны

үр дүнг нийтэд хүргэдэг тулд хөндлөнгийн үнэлгээ заавал хийх шаардлагатай. Шинжлэх ухааны сэтгүүлд анх удаа хэвлэгдсэн **оригинал судалгааг** (original research) анхдагч сурвалж гэж нэрлэдэг. Хоёрдогч сурвалжид шүүмжийн өгүүлэл, ном зэрэг багтана.

**Судалгааны бүтээлийн шүүмж** гэж тухайн судалгаа үнэхээр шинжлэх ухаан хувь нэмэр оруулж буй эсэхийг, гол санаа нь батлагдаж буй эсэхийг, шинэ тутам мэдлэг бүтээж буй эсэхийг гэх мэт эрдэм шинжилгээний судалгаанд зайлшгүй байх ёстой шалгуурыг давах эсэхийг үнэлж буй үнэлгээ гэж болно. Жишээ нь, миний ээж "Трой, чиний өгүүлэл чинь хэт их онол, тоон баримттай хэр нь түүх, хүүрнэлээр дутмаг болж. Чи уул нь сонирхолтой түүх бичдэг дээ, сая яагаа вэ? Дахиад нэг үз дээ" гэж хэллээ гэдэг эрдэм шинжилгээний шүүмжид орохгүй. Гэвч энэ шүүмжид тодорхой үнэ цэн байгаа гэвэл бий. Магадгүй ихэнх хүн "...судалгааны бүтээл бичих бол уйтгартай зүйл... Хэт их мэдээлэлтэй хэр нь түүх, хүүрнэл багатай... Сонин эсвэл TikTok шиг анхаарал татсан биш... Ойлгомжгүй, чамин үг олонтой..." гэх мэтээр шүүмжилдэг. Харин судлаачид өөрсдийн ажлаа "...Судалгааны зохиол мэдлэг тэлдэг... Шинэ түүх бус, шинэ мэдээлэл өгдөг... Мэдлэг бий болгодог болохоос зугаацуулах албагүй... Мэргэжилтэн, шинжээч гээд тодорхой уншигчдад зориулан бичдэг... Нийгмийг ирээдүй рүү хөтөлдөг..." гэх зэргээр өмгөөлдөг.

Мөн эрдэм шинжилгээний ажил гэдэг судлаачийн ажилдаа дуртай байх, гоё сайхан, хүсэл тэмүүлэл, ач холбогдлын тухай өгүүлэмж байдаг. Доорх өгүүлэл, номын бүлэг бүгдээрээ сайн ажил болсон. Мэдээж утга агуулгыг нь ойлгохгүй, тус сэдвээс хол хүнд доорх олон гарчиг утга учиргүй ч санагдаж мэднэ. Жишээ нь, "Winters without women: Social change, split households and gendered labour in rural Mongolia", "After life-of-mine: Rethinking mine closure", "Mongolia: grassland of wisdom and natural beauty", "Desert boundaries: the once and future Gobi", "The new Mongolian state herder: Examining invocations and improvisations of the state in rural Mongolia", "From conflict to a community development agreement: A South Gobi solution", "Herders and hazards: covariate dzud risk in a Mongolian subdistrict" зэрэг судалгааны өгүүллүүд нь үнэндээ монголын тухай их сайн судалгаа юм.

## Судалгааны эх сурвалж

Импакт фактор (impact factor) бүхий нэр хүндтэй сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэл бол нэг төрлийн найдвартай эх сурвалж мөн. Барууны эрдэм шинжилгээний ертөнцөд ихэнх өгүүллийг томоохон сэтгүүл/хэвлэлийн газар нийтэлдэг. Тухайлбал, Elsevier, Taylor & Francis, Springer, Oxford, Nature, MDPI гэх мэт. Эдгээр хэвлэлийн давуу тал нь интернэтэд холбогдсон л бол олох боломжтой бүр зарим нь үнэгүй унших боломжтой байдагт оршино. Түүнчлэн уг өгүүлэл хэр нөлөөтэй байгааг хэр их эшлэгдсэн зэргээс нь мэдэх боломжтой. Нэгэнт их цаг хугацаа зарцуулан хийсэн судалгаагаа хэвлүүлтэл түүнийг чинь хэн ч уншихгүй, ашиглахгүй байвал та яг яах гэж тэр судалгаагаа хэвлүүлсэн бэ гэдэг суурь асуулт хөндөгдөнө. Энэ сайхан боломжийг дагаад "Хуурамч сэтгүүл" хэмээх нэгэн төрлийн мангасаас болгоомжлох хэрэгтэй. Учир нь, уг төрлийн сэтгүүл, хэвлэлийн газар таны судалгааг ямар нэгэн хөндлөнгийн үнэлгээгээр хяналгүй хэвлэж, таны зохиогчийн эрхийг өөртөө авдаг төдийгүй, төлбөр төлөхийг шаардах нь бий.

**Саарал хэвлэл** (grey literature) гэгддэг тайлан, хөндлөнгийн хяналтгүй хэвлэгдсэн зүйлсийг шууд судалгааны анхдагч, үндсэн эх сурвалж болгож ашиглахаас татгалзвал дээр. Учир нь, **анхдагч – оригинал судалгаа, баримт** гэдэгт судалгаа, тоо баримт, эрдэм шинжилгээний судалгаа гэгдэх эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, судалгааны тайлан, цаг уурын тухай тоо баримт, судалгааны нээлт зэрэг орно. Харин **Саарал хэвлэлд** алив нэгэн байгууллага, хувь хүний хэвлэн нийтлүүлсэн материал тухайлбал, эмнэлгийн судалгааны тайлан, хурлын эмхэтгэл, төрийн албан бичиг хэрэг, байгууллагын тайлан, олон улсын агентлаг (НҮБ, Дэлхийн Банк), хувийн харилцаагаар олж авсан зүйл, хэвлэгдээгүй зүйлс, диссертаци, хөндлөнгийн үнэлгээтэй сэтгүүлд хэвлэгдээгүй судалгаа зэргийг багтааж болно. Саарал хэвлэлийг цэгцтэй байдлаар цуглуулж, ангилж, хадгалдаггүй. Тиймээс судалгаандаа ашиглахдаа уян хатан хандаарай. Магадгүй ерөнхий мэдээлэл авахад хэрэгтэй жишээ нь, эдийн засгийн, хүн ам зүйн, цаг уурын гэх мэт мэдээлэл өгч болно. Мөн тухайн материалыг хэвлэн нийтлүүлсэн байгууллага хэр итгэл даахуйц байхаас үнэ цэн нь хамаардгийг анхаарах хэрэгтэй. **Хоёрдогч эх сурвалж гэдэгт** презентаци, анализ, анхдагч эх сурвалжийн шүүмж, тайлбар, тоймлон бичсэн бичвэр зэргийг оруулж болно. Жишээ нь, судлаач Bőrbara Jimőnez - Pazos-

ийн 2021 онд хэвлүүлсэн “Дарвины Зүйлийн үүсэл дэх хэлийг компьютерын тусламжтайгаар шинжилсэн нь” (Darwin Puzzled? A Computer - assisted Analysis of Language in the Origin of Species) ном бол анхдагч эх сурвалж болох Дарвины зүйлийн үүсэл бүтээлийг судалсан судалгаа буюу хоёрдогч эх сурвалж болно.

## Эрдэм шинжилгээний ном зохиолыг хаанаас олох вэ?

Тэр бүхнийг өмнө дурдсан дээр эрдэм шинжилгээний хэвлэлийн газар болох тустай мэдээллийн сангаас олж болно. Жишээ нь, Web of Science, Scopus, Google Scholar, Jstor зэрэг сангаас нийгмийн ухааны олон судалгааг олж болно. Харин математик, физик, инженерчлэлийн чиглэлээр бол Arxiv.org мэдээллийн сан нөөц ихтэй. Гэвч эдгээр санг ашиглах эрх тодорхой төлбөртэй байдаг тул монгол ашиглахад санхүүгийн бэрхшээлтэй байж болох юм. Их сургууль, томоохон номын сан энэ бүх эрхийг худалдан авсан байдаг тул тухайн байгууллагын гишүүнчлэлийн эрх хэрэгтэй болж мэдэх юм.

Эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг мэдэхдээ **мэдээллийн пирамид буюу ач холбогдлоор нь эрэмбэлж** болно. Анхлан академик ном, өгүүлэл уншиж үзээд таны сонгосон сэдвээр хангалттай их шинжлэх ухааны бүтээл байхгүй бол тус сэдвээр судалгаа хийхэд тохиромжгүй байж мэднэ. Таны уншиж буй судалгаа агуулга, үзэл санааны хувьд төвийг сахисан, сэтгүүлзүйн бичлэгийн хэлбэрээс зайлсхийсэн, олон ургалч үзэлтэй, давтан хийх боломжтой байх учиртай.



Энэ бүхнээс үүдэн **эрдэм шинжилгээний өгүүлэл** нь доор хэд хэдэн төрөлтэй байж болно. Тэдгээр нь: **Судалгааны өгүүлэл -** шинэлэг бөгөөд өмнө нь хэвлэгдэж байгаагүй судалгааны ажил. Эх сурвалжийн жагсаалтын хамт нийт 8 мянгаас дээшгүй үгтэй байх. **Товч өгүүлэл** - Хийсэн ажиглалтыг маш тодорхой, нарийн тайлбарлан бичсэн, ном зүй, тайлбар зүүлтийг эс тооцоод 2400 үгээс хэтрэхгүй байх. **Шүүмжийн өгүүлэл** - Байгаа мэдээллийг, тодорхой сэдэв эсвэл судалбал зохилтой сэдвийг шүүн дүгнэх. **Хэлэлцүүлэг өгүүлэл** - эрдэм шинжилгээний өгүүлэлд тусгах санал, 4 мянгаас хэтрэхгүй үгтэй байх. **Номын шүүмж** - 1,500 хэтрэхгүй үгтэй байх зэрэг юм.

### Эрдэм шинжилгээний сэтгүүл

Өмнө дурдсан анхдагч судалгааг хэвлэдэг хэвлэлийг эрдэм шинжилгээний сэтгүүл гэнэ. Жишээ нь, Journal of Arid Environments гэдэг сэтгүүлийн вебсайт дээр тус сэтгүүл нь “дэлхийн хуурай, гандуу газар дахь хүн-байгалийн харилцаа, экологи, хүрээлэн буй орчин, шинжлэх ухааны чухал асуудлын талаар ойлголт өгөх судалгааны өгүүллийг нийтэлдэг олон улсын сэтгүүл юм. Тус сэтгүүл дэлхийн хуурай газарт тулгарч буй нийгэм, шинжлэх ухааны ярвигтай асуудлыг олон талаас нь ойлгохын үүднээс салбар дундын судалгааг чухалчилдаг. Тус сэтгүүл өнгөрсөн, одоо болон ирээдүй дэх хуурай, гандуу газрын тухай судалгааг хэвлэн нийтэлдэг” гэж тодорхойлжээ. Судалгааны өгүүлэл нь олон улсын ач холбогдолтой бөгөөд тодорхой зорилготой, дэвшүүлсэн таамаг, асуултад хариулсан байх ёстой. Судалгааны өгүүлэл нь мэдлэг бий болгож, олон улсын уншигчдад чиглэгдсэн байх учиртай. Тиймээс судалгааны өгүүлэл нь доорх хэсгүүдээс бүрдэж байвал тун сайн. Тэдгээр нь: Удиртгал/судлагдсан байдал - судалгааны сэдэв ба асуулт, судалгаа хийх болсон шалтгаан, судалгааны ач холбогдол зэргийг багтаана. Судлагдсан байдал - тухайн сэдвээр хэвлэн нийтлэгдсэн судалгаа, хөгжүүлсэн онол, мэдлэгийг хураангуйлан өгүүлнэ. Үүнийг сэдэв, эсвэл он цагийн дарааллын дагуу тоймлож болно. Энэ хэсэгт дурдагдсан сурвалж бүр өгүүллийн үндсэн хэсэг болон ном зүйд эшлэгдсэн байх ёстой. Арга зүй - судлаач судалгаагаа хэрхэн хийснийг нарийн тайлбарлана. Судалгааны бүтэц, судалгааны бүлэг, хувьсагч, судалгааны нөхцөл, хийгдсэн ажил зэргийг энд

дурдах шаардлагатай. Гарсан үр дүнг нэгтгэн шинжлэхийн тулд дата анализын аргазүйг ашиглана. Үр дүн - судалгаанаас олж нээсэн зүйлээ тайлбарлаж, дүгнэнэ. Хамгийн гол чухал дүгнэлтээ түрүүнд танилцуулаад, дараа нь бусад үр дүнгээ тайлбарлана. Мэдээлэл (data), хүснэгт, зураг, эшлэл зэрэг байх боломжтой. Хэлэлцүүлэг (Discussion) - Энэ хэсэгт тухайн судалгааны оруулж буй хувь нэмэр, түүнээс олж авсан мэдлэгийг практик дээр хэрхэн ашиглаж болох талаар саналыг тусгана. Түүнчлэн судалгааны давуу болон сул талыг тайлбарлана. Ном зүй буюу ашигласан судалгаанyхаа жагсаалтыг багтаана.

**Сэдвийн судлагдсан байдлыг хэрхэн бичих вэ?** гэдэг таны судалгаа ямар болохыг шийддэг хэдэн чухал алхмын нэг юм. Сонирхсон сэдвээ хэр сайн ойлгож байна, хэр сайн мэдэж байгаа тань таны судалгааны чанарт ч нөлөөлнө. Тиймээс судалгааны бэлтгэл ажлын үеэр сонгосон сэдвийнхээ хүрээнд бүхий л боломжит баримт материалыг цуглуулах хэрэгтэй. Энгийнээр бол чадах хэрээрээ их уншин сэдвээ дахин тодорхойлж, судалгаа хийх төлөвлөгөө гаргаж, цэгцтэй, системтэйгээр ажиллах хэрэгтэй. Энэ хоорондоо нэр томьёонуудыг тайлбарлах, судалгааны асуултаа, судалгааны арга зүйгээ тодорхойлохоо мартаж болохгүй.

Аливаа өгүүллийн шууд уншихын оронд сэдэвт чинь хамааралтай эсэхийг тодорхойлох юуны түрүүнд хураангуйг унш. Дараа нь удиртгал, дүгнэлтийн хэсгийг уншиж болно. Уншиж буй өгүүллийн чинь гол нэр томьёо, концепциуд нь юу вэ, дэвшүүлсэн аргумент нь тодорхой байна уу, эх сурвалж нь ямар байна, миний судалгаанд хамаатай юу, аргументаа хэрхэн дэвшүүлсэн байна, чиний судалгаатай хамаатай байна уу, найдвартай эх сурвалж мөн үү, судлагдаагүй үлдсэн хэсэг байна уу гэх мэтийг байнга анхаарч байх хэрэгтэй.

**Хөндлөнгийн үнэлгээ (Peer review)** нь аливаа судалгааг хэвлүүлэх үндсэн шалгуур болж байдаг давуу талтай юм. Тухайн сэдвээр мэргэшсэн судлаачид өгүүллийг чинь уншиж, санал дүгнэлтээ хэлнэ. Тэд өгүүллийг чинь хэвлэх, засварлах эсвэл татгалзах эсэхээ шийддэг. Мөн өгүүллийг чинь хэрхэн сайжруулж болох талаар саналаа (судалгаа, бичлэгийн хэлбэр, дүрс баримт, бүтэц гэх зэрэг) хэлж болно. Энэ үйл явц хэдэн сарын хугацаа шаардагдаж болох ч хэт их удвал сэтгүүлийн редактортай холбогдоорой.

Өмнө дурдсан **Хуурамч сэтгүүлээс (Predatory journal)** болгоомжлох хэрэгтэй. Та нэгэнт бичиж дууссан өгүүллээ аль нэг сэтгүүл рүү илгээхээс өмнө хэвлэлийн хөлс төлөх шаардлагатай эсэхийг нягтлаарай. Үнэгүй сэтгүүлүүд бий боловч сүүлийн үед олон сэтгүүл төлбөр авдаг болсон. “Open Access” буюу нээлттэй өгүүллүүд төлбөртэй байдаг тул судлаач та өөрөө төлбөр төлөх хэрэгтэй болж мэдэх юм. Гэвч энэ төрлийн сэтгүүлийг хуурамч сэтгүүлтэй андуурч болохгүй. Хуурамч сэтгүүл нь “Мөнгөө төлөөд, хөндлөнгийн хяналтгүйгээр юу хүссэнээ хэвлүүл” гэсэн зарчимтай бол Нээлттэй өгүүлэл нь зохих ёсны бүх хөндлөнгийн үнэлгээг хийж, зөвшөөрөгдсөн тохиолдолд хэвлэдэг юм. Өөрөөр хэлбэл, та хэвлүүлсэн өгүүллээ бусдад үнэгүй уншуулахын тулд төлбөр төлж буй гэсэн үг. Хуурамч сэтгүүл таныг мэйлээр ангуучлах болно. Манайх ийм сайн сэтгүүл, манайд өгүүллээ хэвлүүлээрэй, бид маш хурдан хэвлэж өгөх болно зэргээр таны толгойг эргүүлэх гэж үзнэ. Ийм төрлийн сэтгүүлд өгүүллээ хэвлүүлэхгүй байх хэрэгтэй. Та мэргэжлийн нэр хүнд, карьертаа ингэж сэвтээж болохгүй.

### Тус бүлгийн даалгавар

Та доор байгаа хэрээний тухай жижиг бичвэрийг уншиж үзээд өөрийн судалгаандаа ашиглах эх сурвалжаа ангилж үзээрэй. Ингэхдээ сэдвийнхээ дагуу мэдээллийн пирамид бэлтгэж, сонирхолтой мэдээллийг баримтаас ялгахаа мартав. Та өөрийн судалгаандаа ямар мэдээллийн эх сурвалжийг ашиглах вэ, яагаад гэдгээ байнга анхаарч байгаарай.

### Хэрээ ваар хоёр

2600 жилийн өмнө Эзоп ийн бичжээ: “Гантай зун тохиож, шувууд уух ундгүй болсон үед нэгэн цангасан хэрээ ёроолдоо жаахан устай ваар олжээ. Гэвч ваар нь урт нарийн хоолойтой учир хэрээ хэдий хичээвч усанд хүрч чадахгүй байв. Ингээд цангаж үхэх нь гэж бодож байтал түүнд нэг санаа төрөв. Хэрээ жижигхэн чулуу түүж ваар луу нэг нэгээр нь хийв. Ингэснээр вааран дахь ус дээшилж уухад амар болжээ.” *Магадгүй та энэ хэсгийн Хэрээ ухаантай гэсэн судалгааныхаа удиртгал хэсэг ашиглаж болох юм.*

Британника нэвтэрхий тольд “Хэрээнүүд маш ухаалаг бөгөөд чадварлаг дуурайгчид. Долоо хүртэл тоолж чаддаг сургуультай хэрээнүүд бий. Зарим хэрээ 100 гаран үг, 50 орчим бүтэн өгүүлбэр хэлж, эзнийхээ хоолойг дуурайн дуугарч нохой, морийг дуудах, шоглох зэргээр харьцдаг. Тэд маш сониучаас гадна сэргэлэн, овжин, шооч гэгддэг. Хүмүүсийн захиаг шүүрч нисэж, машины түлхүүр бас бус жижиг зүйлсийг хулгайлдаг. Модоор нүх сүв малтаж хоолоо олж иддэг хоёр зүйлийн хэрээ бий. Ийм чадвартай цөөн төрлийн л амьтан байдаг.” *Энд таны Хэрээ ухаантай гэсэн судалгаанд хэрэг болох сонирхолтой мэдээлэл байгаа юм биш биз?*

Английн Daily Mail сонины 2019 оны нэгэн дугаарт Тагнуул хэрээнүүд нэртэй мэдээ нийтлэгдэв. Тэнд: “Хүйтэн дайны үеэр АНУ-ын Тагнуулын төв газар хэрээг сургаж ЗХУ-г тагнахад ашигладаг байсан тухай мэдээлэл архивын баримтаас олджээ. До Да хочтой хэрээ АНУ-ын Тагнуулын төв газрын хүндтэй тагнуулчдын нэг байв. Тэр ширүүн нөхцөлд тэсвэртэй, хүнд ачаа даах чадалтай, халдлагыг зогсоох чадвартай байжээ. АНУ арваад жилийн турш амьтдыг тагнуулын ажилд сургах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд До Да тус хөтөлбөрийн хамгийн чухал дүр нь байв. Хүйтэн дайны үед До Да ЗХУ-ын эсрэг тэмцэхэд хувь нэмрээ оруулж байжээ. До Да нэг өдөрт далайн эргээс усан онгоц хүртэл 10 орчим км, буцаад далайн эрэг хүртэл 6.5 км нисэхийг гуравхан сарын дотор сурчээ. Тэр Оросыг тагнах ажилд дайчлагдахаар бэлтгэгдэж байсан ирээдүйтэй тагнуулчдын нэг байв. Гэвч сургуулилтын үеэр энгийн хэрээнүүд түүн рүү дайрснаас хойш тэр дахиж үзэгдээгүй юм. Түүнийг сургаж байсан эрдэмтэд үүнд маш их харамсжээ. До Да маш авьяаслаг бөгөөд олны хайрыг татсан хэрээ байсан тухай нэг эрдэмтэн бичиж үлдээжээ.” *Үнэхээр хэрээ тагнуулж хийж байсан гэж үү? Итгэж болох мэдээлэл үү? Жаахан сэтгүүл зүйн шинжтэй бичигдэж дээ?*

CNET телевиз 2014 онд нэвтрүүлсэн “Хэрээ хүүхдээс илүү ухаантай нэртэй” нэвтрүүлэгтээ “Шинэ Каледоны хэрээнүүд 7-10 настай хүүхдүүдийн түвшинд сэтгэх чадвартайг судалгаа харуулж байна. Устай аяганд чулуу хийснээр усны түвшнийг дээшлүүлэх боломжтой гэдгийг бид мэднэ. Тэгвэл хэрээнүүд мөн үүнийг ойлгодог гэдгийг Аукландын их сургуулийн Сара Жэлбэрт харуулжээ. Түүнчлэн хэрээнүүд усанд хөвөх эсвэл живэх зүйлсийг ялгаж чаддаг бөгөөд элс ба ус хоёрын ялгааг мэддэг ажээ. Калифорнийн их сургуулийн Корина Логаны удирдлага дор явуулсан судалгааны

үр дүнд хэрээнүүд усны эзлэхүүний ялгаж чаддаг болохыг олжээ.” *Энд хоёр ч судлаачийн судалгааг эшлэн ашигласан байна. 2600 жилийн өмнө бичигдсэн түүхийг хэлж байгаа ч гэсэн энэ судалгааг уншмаар санагдаж байна шүү.*

Queen of the Corvids – Guardian UK, 2022 сонинд “Эзопын “Хэрээ ваар хоёр” үлгэрт гардаг шиг хэрээ үнэхээр усанд чулуу хийж, түвшнийг нь дээшлүүлж чаддаг болохыг судалгаа харуулсан. Бас нэгэн судалгааны үр дүнд хэрээ хэдий ердийн үед зэр зэмсэг хэрэглэдэггүй боловч шаардлагатай үед сэтгэж, зэр зэмсэг хийх чадвартай, жишээлбэл худгаас хувинг татаж гаргахын тулд дэгээнд утас залгаж хийж чаддаг болохыг тогтоожээ. Судлаач Клаитон “Шувууд гайхалтай ухаантай, би тэднийг хүндэлдэг гэв”. *Энэ хүний судалгааг уншмаар болж байна уу?*

Эмэри, Клаитон нар Science сэтгүүлд “Хэрээний сэтгэх чадвар: Хэрээ болон бичний оюун ухааны хувьслын төстэй тал” нэртэй өгүүлэл хэвлүүлжээ. Тэнд: “Оюун ухааны хувьслын талаар хэлэлцэхэд ихэвчлэн хүнтэй хамгийн ойр төрөл болох сармагчин, бичнүүдийг авч үздэг. Хэрээ зэрэг тархины хэмжээ томтой бусад амьтад ч амьдран буй орчныхоо физикийн болон нийгмийн хуулийг ойлгодог ажээ. Энд хэрээний тухай сүүлийн үеийн судалгаануудыг авч үзье” гэх мэтээр бичжээ. *Энэ өгүүллийг унших хэрэгтэй юм шиг санагдаж байна уу?*

## Сэдэвтэй холбоотой унших бүтээл


Effron, S.E. and Ravid, R. 2019. Writing a Literature Review: A Practical Guide.

Knopf, J.W. 2006. Doing a Literature Review. Political Science and Politics 39 (1): 127

Lombard, E. 2010. Primary and Secondary Sources. Journal of Academic Librarianship, 36, 3, pp. 250-253.

Oliver, Paul. 2012. Succeeding with your literature review: A handbook for students.

Paul, Justin, and Alex Rialp Criado. 2020. “The art of writing literature review: What do we know and what do we need to know?.” International Business Review 29.4: 101717

# БҮЛЭГ 3:

## СУДАЛГААНЫ СЭДЭВ СОНГОХ

ТРОЙ СТЕРНБЕРГ

## Хичээлийн тухай:

Эрдэм шинжилгээний судалгаа хийхэд хамгийн эхний бөгөөд чухал алхам нь сайн сэдэв сонгох юм. Сэдэв нь судлаачийн өөрийн сонирхлыг төрүүлж, тухайн судалгааны салбарт ач холбогдолтой байх ёстой. Түүнчлэн, сэдэв нь бодит байдалд нийцсэн, судлаачийн ур чадварт таарсан, сургуулийн/төслийн шаардлагыг хангасан байх хэрэгтэй. Том санаанаас сэдвээ хэрхэн нарийвчлах нь чухал. Сэдэв нь зорилтод уншигчдад чиглэсэн, хангалттай мэдээлэлтэй байх шаардлагатайгаас гадна судлаачийн хувийн болон мэргэжлийн зорилгод нийцэж байх хэрэгтэй. Сэдвээ зөв сонгож байж хүссэн үр дүндээ хүрэх боломжтой болно. Сайн сэдэв, судалгааны загвар, бүтэц амжилттай судалгааны суурь юм.

## Яаж сайн судалгааны сэдэв сонгох вэ?

Нэн тэргүүн та өөрөө сэдвээ сонирхдог байх ёстой. Танд юу урам зориг өгдөг вэ, цагаа юунд зарцуулмаар байна вэ, ямар мэдлэг, чадвараа хөгжүүлмээр байна вэ, таны бодит боломж чинь юу вэ, зарцуулах цаг, санхүүжилт хангалттай юу гэдэг суурь асуултыг эхлээд өөрөөсөө асуух хэрэгтэй. Мэдээж дэлхийн ертөнцөөр дүүрэн судалж болох сэдэв бий. Жишээ нь, монголын хувьд судалчихмаар сэдэв их байгааг доорх зургаас хараарай.



Тэр олон сэдэв дундаас судалгааны/төслийн шаардлагад нийцсэн, баримтаар нотлогдохуйц, ач холбогдолтой, шинэ мэдлэг бий болгоход хувь нэмэртэй сэдэв сонгох хэрэгтэй. Магадгүй та эрдэм шинжилгээний өгүүлэл эсвэл магистр, докторын судалгааны ажил бичих гэж байгаа бүүр эсвэл аль нэг судалгааны төсөлд өрсөлдөж байлаа ч гэсэн дээрхийг байнга санаж байх хэрэгтэй.

Сайн сэдэв сонгохын тул эхлээд сайн унших хэрэгтэй. Агуулга, контекстийг ойлгохгүйгээр сайн сэдэв сонгох боломж хомс. Сонирхол татаж буй сэдвээрээ бусадтай ярилц, шүүмж сонс, үнэхээр тэр сэдэв өөрт чинь тохирох уу гэж бод. Хэт өргөн хүрээтэй байвал улам нарийвчилж, илүү төвлөрсөн шинжтэй болго. Та тодорхой хэмжээний уншсан, үзсэн, хэлэлцсэн зүйлс байгаа тул тэр бүхэнтэйгээ холбож эргэцүүлж бод. Чиний сонирхлыг татдаг зүйл, чи хүмүүст ямар мэдлэг, мэдээлэл хүргэмээр байна вэ? Бусдыг сонсож, хүмүүс ямар бодол, байр суурьтай байна вэ? юунд санаа зовниж байна вэ? гэдгийг анхаар. Яг одоо болж байгаа үйл явдал, өөрчлөгдөж байгаа нөхцөл байдлыг анхаарч ажигла. Сэдэв чинь үндэстний, бүс нутгийн, бүх нийтийн хэмжээнд ач холбогдолтой юу? Тиймээс сэдвээ бодит амьдралд нийцүүлэх хэрэгтэй.

Танд олон боломж байгаа түүнтэйгээ харьцуулан бод, багш, найз нөхөд, бусад судлаачидтай ярилц, зоригтой бай, тухтай орчноосоо (comfort zone) гар, боломжит сонголтуудаа эхлээд жагсааж бичээд, харж эргэцүүлсний дараа хэрэггүй гэж үзсэнийгээ хас. Сонгосон сэдэв чинь судлахад ач холбогдолтой, хангалттай цар хүрээтэй, анализ шинжилгээ хийж болохуйц байх учиртай. Сэдвийг судлахад хангалттай материал хэрэглэгдэхүүнтэй байх хэрэгтэй. Хээрийн судалгаа, мэдээлэл, ярилцлага, эх сурвалж, ном зохиол арвин байвал сайн. Хэт нарийн сэдэв сонгохоос зайлсхийхгүй бол сонирхолтой байж болох боловч хангалттай материал олдохгүй байж магад юм. Тиймээс судалгааны материал бий эсэхийг шалга. Уншигчидтайгаа харилцах буюу багш, оюутан, мэргэжилтэн, олон улсын уншигч зэрэг сэдвийг чинь уншиж ойлгох хүмүүсийн талаар ч бодолц. Мөн яагаад судалгаа хийж байгаа вэ гэдгээ ч байнга бодож байх хэрэгтэй. Магадгүй та салбартаа мэргэших, PhD зэрэгтэй болох, Ажилд орох/орлоготой болох, туршлага хуримтлуулж, аялах, нийгэм, улсдаа хувь нэмрээ оруулах зэрэг янз бүрийн зорилготой байж болно. Тэр бүхэн чинь судалгааны тань сэдэвтэй холбогдож байх ёстой.

Ээжийнхээ үгийг **битгий сонс.** Магадгүй ээж чинь "хэрээнүүдийг судалбал сонирхолтой шүү дээ. Хэрээ ярьж, бас бодож сэтгэж чаддаг, сургаж болдог. Судалгааны маш гоё сэдэв шүү. Манай Сиатл хот хэрээ ихтэй. Хэрээний талаар бичсэн ном зохиол ч олон..." гэж болох юм. Чи гэтэл "Өө, би Монголын газар зүйг судалмаар байгаа" гэтэл ээж чинь "Тэнд ч бас хэрээ байдаг гэдэгт итгэлтэй байна" гээд байвал яах вэ? Чи судалгааны сэдэв сонгох гэж байгаа ээж чинь биш. Тиймээс **өөрөөсөө асуу** - Миний судалгаа хэрэгтэй юу, тус сэдвээр дутуу, судлагдаагүй орхигдсон зүйл бий юу, миний сонгосон сэдэв судалгааны зорилгод минь нийцэх үү, миний мэдлэг, ур чадвар судалгаа хийхэд хангалттай юу, би ахиад юу сурах шаардлагатай вэ гэх мэтийг дахин дахин асуу. Магадгүй чи статистик, судалгааны арга, шинэ хэл, шинжлэх ухааны аргачлал, онол, соёл шашин, идээ ундаа, нийгэм, зайнаас тандан судлах арга, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах талаар сурах шаардлагатай байж мэднэ. Мөн та судлаачийн хувьд хангалттай мэдлэг чадвартай, бие физиологийн хувьд бэлэн үү, ургамал хоолтон бол монголын хөдөөд идэх зүйл хэр олдох вэ гэх мэтийг ч бодолцох хэрэгтэй болно.

## Судалгааны орон зай

Тухайн сэдэв өмнө судлагдсан уу, судалгаа хэрхэн өөрчлөгдсөн бэ гэдгийг анхаарч байх хэрэгтэй. Жишээ нь, Монголын Социализмын үе (1990 оноос өмнө) vs. Постсоциализмын үед (1990 оноос хойш), Ковид цар тахлаас өмнө ба дараагийн нөхцөл байдал өөр өөр, судалгааны хандлага ч их ялгаатай болсон байгаа. Судлагдсан байдал дундаж гэж болмоор буюу судалгаа хийхэд ач холбогдолтой, ерөнхий судалгаа ихтэй сэдэв байж болно. Гэтэл бага судлагдсан ч сайн сэдэв байж болох, үр дүнтэй аргумент боловсруулж, баримт цуглуулж, санхүүжилт олдохоор сэдэв ч байх боломж бий. Үүний эсрэг хэт их судлагдсан, шинэ зүйл олж мэдэх боломж бага, өмнөх судалгаануудад олон давтагдсан сэдэв ч байж болно.

Дээрх бүх сул талаас зайлсхийхийн тулд сэдвээ сайн судалж, бусад оронд хийсэн судалгаанаас санаа авч болно. 'Нүүдлийн мал аж ахуй', 'уур амьсгалын өөрчлөлт', 'цөл', 'сүү цагаан идээний соёл', 'уул уурхай ба хүмүүс' гэх мэт одоо ч сонирхолтой байгаа сэдэв цөөнгүй. Мөн зөвхөн судалгааны дэг сургууль, нэг салбарт

баригдалгүй. Газар зүй, антропологи, хүрээлэн буй орчин, хөгжил судлал, зайн тандан судалгаа, түүх, социологи, эрүүл мэндийн салбарын судалгааг ч гэсэн анхаарч байх хэрэгтэй. Мөн өөрийн академик орон зайгаа тооцож үзэх хэрэгтэй. Жишээ нь, монголд судалгаа хийдэг Барууны газар зүйч цөөн, цөөхөн монгол эмэгтэй газар зүй, эсвэл физикийн судалгаа хийж байгаа нь магадгүй та салбартаа хурдан мэргэжилтэн болох боломжтойг илэрхийлж байна.

**Сэдвийн хүрээгээ** тогтоохын тулд сэдвээ тодорхойлох үгсээ оновчтой болго. Монгол Улс, хүрээлэн буй орчин, ган, малчид, худаг ус, постсоциалист, ургамал, мал, зуд, Говь гэх мэт оновчтой үгээр сайн судалгааг хайж олох боломжтой. Энэ мэт түлхүүр үгээр олсон мэдээллээ өөрийн сонирхон судлах цаг үеийг сонгох илүү нарийвчилж болно. Жишээ нь, түүхэн талаас уу, орчин цагийн байдлыг уу бичих үү гэдгээс болж сэдвийн хүрээ улам тодорхой болно. Мөн хэнийг буюу зорилтот бүлгээ хөдөөгийн орчин, малчид, хотын бус хүмүүс эсвэл Гурван сайхан, Булган, Баяндалай сум зэргээр зэргээр байрлалаа тодорхойлбол бүүр илүү нарийвчлалтай сэдэв болно. Улмаар сэдвээ бусад судалгаатай холбохын тулд тус газарт өмнө хийсэн судалгаа эсвэл Африкт ч юм уу хийсэн ижил төстэй судалгаатай харьцуулж, баяжуулж болно.

**Судалгааны бүтэц, цагийн хуваарийг тодорхой гаргах хэрэгтэй.** Жишээ нь, та докторын судалгаа хийх гэж буй бол эхнээс нь ажлаа цэгцтэй зохион байгуулах хэрэгтэй. Эхний жилийг бэлтгэл ажил, унших, судалгааны загвараа боловсруулахад зарцуулах бол хоёр дахь жил судалгаа, хээрийн судалгаа, ажиглалт зэргээ хийнэ. Харин гурав дахь жил анализ шинжилгээ, бичих, танилцуулах ажлаа хийх бол дөрөвдөх жил сэтгүүлд өгүүллээ хэвлүүлэх, дипломын ажлаа дуусгах, хамгаалах, шалгалтаа өгөх гэх мэт ерөнхий төлөвлөгөөтэй байх нь дамжиггүй.

## Сэдвээ илүү тодорхой болго

Том сэдвээс эхлээд улам нарийн, тодорхой болгох хэрэгтэй. Энэ ажилд их хугацаа орж, замдаа та бодлоо өөрчилж магадгүй. Гэвч ерөнхий сэдвээс илүү төвлөрсөн, нарийн санаа гарга. Жишээ нь, Говь ус - бэлчээр ургамал - худаг уур амьсгал – ган - зуд гэсэн ерөнхий санаанаас Говь - бэлчээрийн ашиглалт – амьжиргаа -

уур амьсгал - цөлжилт гэсэн сэдэв урган гарч болно. Одоо ямар арга зүйгээр үүнийг судалж болох вэ гэж бодвол ус шинжлэх - ярилцлага - уур амьсгалын шинжилгээ гэх мэтээр хөвөрч болов юм. **Магадгүй олон судлаач сэдэв сонгохдоо хувийн сонирхлоо дагасан байж болно.** Жишээ нь, Трой аялах дуртай, Говь цөл газарт дуртай, Азид дуртай, АНУ-д амьдрах хүсэлгүй, учир нь, шинэ соёлтой танилцах хүсэлтэй, гэтэл Азиуд ажилсаг, сонирхолтой өвөрмөц хүмүүс. Тиймээс тэдний дунд байж үзвэл яах вэ, магадгүй хээрийн судалгааны ажил байж болно. Гэтэл түүнийгээ хийхийн тулд шинжлэх ухааны судалгааны арга зүйг суралцах хэрэгтэй болсон. Ингээд туршлага сууж, анализ шинжилгээ хийх чадвартай болж, эцэстээ мэргэжилтэн болон, шинжлэх ухааны мэдлэгт хувь нэмрээ оруулах хэмжээнд хүрчээ гэх зэргээр байж болно.

Мэдээж энэ бүхнийг хийхэд тодорхой **академик шаардлагууд** бий. Жишээ нь, докторын зэргээр аль нэг сургуульд сурах гэж буй бол чиний сургалтын хөтөлбөр эсвэл төсөл ямар шаардлагуудтай байх вэ гэдэг чухал. Судалгааны ажлын тань үгийн тоо хэд байх ёстой вэ, формат, эцсийн хугацаа, сэдвээ өөрөө сонгох уу эсвэл багш/төслөөс чинь сонгож өгөх үү, энэ судалгааны дараах чиний зорилго юу вэ, профессор, судлаач болох уу эсвэл ажилд орох, төрийн албан хаагч, консалтинг үйлчилгээний салбарт ажиллах уу зэргээ тооцон судалгааны сэдэв сонгож болно.

Өмнө дурдсанчлан судалгааны олон төрөл бий. Шинэ мэдээлэл цуглуулах, туршилт хийх, хээрийн судалгаа хийж анхдагч эх сурвалж бүтээх үү эсвэл байгаа мэдээллийг буюу үндэсний статистик, уур амьсгалын тухай мэдээлэл, архив зэргийг шинжлэн үзэх үү. **Ач холбогдол** гэдэг зүйлийн байнга анхаарах хэрэгтэй. Зөвхөн өөрт чинь сонирхолтой сэдэв байж бас болохгүй. Танд сонирхолтой нь сонирхолтой. Гэхдээ хэр ач холбогдолтой сэдэв вэ? **Судалгааны ач холбогдол** гэдэг нь мэдээллийн цоорхойг нөхөж, тухайн салбарт шинэ хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой сэдэв юм. Мөн **нийгмийн ач холбогдол**той сэдэв нь нийгмийн тухай бидний ойлголтод хувь нэмэр оруулж, нийгэмд өөрчлөлт бий болгодог байж болно. Гэтэл **практик ач холбогдол**той буюу бодит асуудлыг шийдвэрлэхэд, амьдралын нөхцөл сайжруулахад нэмэртэй сэдэв байж болно. Өнөөгийн нийгэм, асуудал, хэлэлцүүлэгтэй холбоотой "Ковидын дараах сэргэлт", "Монгол дахь уур амьсгалын өөрчлөлт",

“Хөдөөгөөс хот руу шилжилт хөдөлгөөн”, “Уул уурхайн нийгэмд үзүүлэх нөлөө” зэрэг сэдэв байж болно.

Аль болох удаан хугацаанд чиний сонирхлыг татах сэдэв сонго. Өөрт байгаа нөөц боломжийг буюу цаг, мөнгө, танил тал зэргээ тооцоол. Анхаарлаа удаан хугацаанд хадгалах чадвартай бай. Сэдэвтэйгээ холбоотой бүх зохиол бүтээлийг унш. Заавал унших зүйлээс гадна, судалгааг чинь илүү тэлж сонирхолтой болгох зүйлийг нэмж хай. Онолын суурь баримтлалаа тодорхойл. Өөрийнхөө хувь нэмрийг оруулж чадах орон зайг ол. Илүү ихийг сурч мэдэх хэрээрээ сэдвээ хөгжүүлж, өөрчилж болно. Мэдээж мэргэжилтнүүдийн санал, зөвлөгөөг сонс.

Дээр ярьсан бүхний жишээ болгож **Монголын талаарх зарим судалгааны сэдвийг** сонирхоцгооё. “Монгол хэлний үгүйсгэлийн тухай судалгаа”, “Азийн орнитомимозаврууд”, “Гадаад Монгол дахь Орос, Хятадын бодлого, 1911-1921”, “Монгол дахь ардчилсан шилжилтийн боломжууд”, “Монголын ирвэс, мазаалай, зэрлэг тэмээний экологи, ажиглалт”, “Хувьсгалт Монгол шашнаа сонгов: Ламаизм уу? Ленинизм үү?”, “Монгол үйл үгийн морфологи”, “Халх аялгууны дуудлага, хэмнэл” зэрэг олон сонирхолтой судалгаа өмнө хийгджээ.

## Сэдэвтэй холбоотой унших бүтээл

Agee, J. 2009. Developing qualitative research questions: a reflective process. International Journal of Qualitative Studies in Education 22(4): 431-447.

Bell, J. 2010. Doing Your Research Project. Open University Press

Bryman, Alan. 2005. The Research Question in Social Science Research: What is its Role? International Journal of Social Research Methodology. 10:1, 5-20.

Kanewiyakiho, Elder Delvin, Sawchuk, Katrina F., and Ramsden, Vivian R. “Ask before You Ask Co-developing Meaningful Research Questions with Indigenous Elders.” Canadian Family Physician 67.12 (2021): 947-48

Sandberg, Jųrgen, and Mats Alvesson. “Ways of constructing research questions: gap-spotting or problematization?.” Organization 18.1 (2011): 23-44

White, P. 2009. Developing Research Questions: A guide for Social Scientists. Palgrave Macmillan, Basingstoke.

# БҮЛЭГ 4:

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙГЭЭ СОНГОХ

АРИЕЛ АХЭРН,
И.БЯМБАБААТАР

## Хичээлийн тухай

Сүүлийн жилүүдэд нийгмийн шинжлэх ухаанд олон шинэлэг, бүтээлч судалгааны арга гарч ирж байна. Урлагт суурилсан судалгааны арга нэлээд түгээмэл болох шинжтэй байгаа юм. Авто-угсаатны зүй, оролцооны зураглал, холимог аргууд нь судалгааны үндсэн аргад мөн нэвтэрч эхлээд байна. Гэсэн хэдий ч энэ хэсэгт нийгмийн шинжлэх ухааны мэдээлэл цуглуулах гурван сонгодог аргыг авч үзэх болно. Тэдгээр нь ярилцлага, оролцон ажиглалт, угсаатны зүйн аргууд юм. Эдгээр аргын үндэс нь ажиглалт, туршлага судлах хэлбэр, харилцаа холбоо, тайлбар хийх зэрэг болно. Бид эдгээр аргын давуу болон сул тал, тэдгээрт шаардагдах ур чадвар, ямар төрлийн мэдээлэл дээр аргуудаар цуглуулж болох талаар ярилцах юм.

## Ярилцлагын арга

Ярилцлагын арга нь “Тодорхой нөхцөл дэх хүний үйлдлийг ойлгох, хүмүүсийн харилцааг судалж, хүмүүс юу мэдэрч, ямар үйлдэл яагаад хийдэг талаар аль болох ихийг олж мэдэх” (McDowell 2010) явдал юм. Мөн “Хүмүүсийн туршлага, үзэл бодол, үнэт зүйлс, хүсэл эрмэлзэл, хандлага, мэдрэмжийн талаар баялаг ойлголт өгөхөд хэрэгтэй” (May 2001, 120) арга билээ. Уг аргын давуу тал нь нарийн ярвигтай зан, үйл явдлыг ойлгох, өөр аргаар олж авсан материалаа баяжуулах, дутуугаа нөхөх, шинэ сонин санаа, мэдээлэлтэй болоход их хэрэгтэй байдаг.

Хүмүүс өөрсдийн хийсэн түүхэн үйл явдал, өөрсдийн хийсэн үйлдэл, гаргасан шийдвэрийнхээ талаар хэрхэн ярьдаг вэ, маргаантай, төвөгтэй асуудлын талаар хүмүүс ямар үзэл бодолтой байдаг вэ, нэг асуудлын талаар өөр өөр үзэл бодол байх боломжтой юу, нийгмийн үнэт зүйлс, хэвшил, дадал зуршил, аливаа зүйлийг хийх арга замыг ойлгох, нутгийн мэдлэг, туршлагаа ойлгох зэрэгт ярилцлагын арга их нэмэртэй байдаг. Ярилцлагын аргаар олж авсан мэдээллээ эх сурвалж болгон ашиглахдаа бодит мэдээлэл авсан эсэхээ анхаарах хэрэгтэй. Ярилцагчийн тань хүлээн авах байдал бодит байдалтай хэрхэн нийцэж байгааг хянах учиртай. Цуглуулсан мэдээллээ шинжлэхдээ ярилцагч тань өөрийн ертөнцийг хэрхэн, юу гэж ойлгож байна вэ, ямар итгэл үнэмшилтэй байна вэ (тэр нь “үнэн” эсэх нь хамаагүй) гэдгийг сайн анхаарах хэрэгтэй юм. Ярилцлагын хэд хэдэн төрөл бий. Тэдгээр нь:

- Амьдралын түүх
- Явган ярилцлага
- Фото зураг үзүүлж ярилцах
- Гол хүмүүстэй (key informant) ярилцах
- Бүтэцтэй
- Хагас бүтэцтэй
- Албан бус зэрэг байж болно.

Энэ аргаар судалгаа хийхээсээ өмнө **судлах хүмүүсээ тодорхойлох** хэрэгтэй. Ямар бүлэг хүмүүстэй ярилцах сонирхолтой бөгөөд хамгийн баялаг, ач холбогдолтой мэдээллийг өгөх вэ, ямар бүлгүүдийг хасах вэ, хэрхэн түүвэрлэх вэ гэдгээ тогтох ёстой. Жишээ нь, зориудын түүврийн аргаар тодорхой шалгуур тогтоож болох бол "Цасан бөмбөг" түүврийн аргаар заавал тэгэх алба үгүй. Ерөнхийдөө түүврийн хэмжээний талаар тогтсон зөвлөмж байдаггүй ч хангалттай гэж үзэх хүртлээ түүвэрлэж болно. Тэрхүү хэмжээ нь ихэнхдээ 15-60 хүн байхад болдог.

**Ярилцлагын бэлтгэл** ажлыг бүрэн хангах нь тун чухал. Эхлээд ярилцлагын удирдамж гаргаж, тодорхой асуулт/ярилцмаар байгаа сэдвийн жагсаалтыг гаргах хэрэгтэй. Судалгааны талбар дээр очсон үедээ судалгааны асуулт, мэдмээр байгаа зүйлийнхээ тухай ярилцагчдаа сайн ойлгуулах ёстой. Ярилцлага бол асуулга биш гэдгийг анхаарч заавал бэлдсэн асуултынхаа дарааллын дагуу ч юм уу эсвэл бүгдийг нь нэг дор асуух гэж хүчлэх хэрэггүй. Ингэвэл таны мэдээллийн чанарт муугаар нөлөөлнө. Тиймээс ярилцлагаа аль болох харилцан ярианы хэлбэртэй байлгавал зүгээр.

**Асуултын төрөл** гэж бий. Тэдгээрийг нээлттэй болон хаалттай, тодорхойлох, норматив, Нарийн vs хийсвэр, маргаангүй, маргаантай, өдөөсөн, идэвхгүй, залах чиглүүлсэн зэргээр ангилж болно. Залан чиглүүлсэн болон хаалттай (тийм/үгүй гэж хариулагдах) асуултаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Нээлттэй асуулт гэдэгт та энэ талаар юу гэж бодож байна вэ, энэ ямар санагдаж байна вэ, энэ талаар чиний бодлыг сонсмоор байна, тэр явдлыг дурсахад, хэр их зэрэг ярилцагч чинь аль болох өөрийнхөө үгээр, ойлголтоор чөлөөтэй хариулах боломжтой асуултыг багтааж буй юм. Харин хаалттай асуулт гэдэг ярилцагч чинь хэдэн үгээр хариулах, эсвэл тийм, үгүй гэсэн

тодорхой хариутай, та хоёрыг яриа цааш өрнөх боломжийг хааж байгаа асуултыг багтаана. Жишээ нь, чи өөрөө хүүхэдгүй учраас чамд ингэж санагдаж байгаа байх тийм үү, чи өмнө нь багш байсан болохоор мэдэж байгаа байгаа биз, чи улс төрчдийг авлигачид гэх гэсэн биш үү гэх мэт хэв маягтай асуулт зэрэг орно.

**Судалгааны асуултаа ярилцлагын асуулттайгаа хольж, хутгаж, андуурч болохгүй.** Судалгааны асуулт гэдэг нь та яг ямар сэдэв, ойлголт сонирхон судалж байгааг хэлж буй бол ярилцлагын асуулт гэдэг нь тэрхүү ойлголт, сэдвийнхээ тухай илүү мэдэхийн тулд асууж буй асуулт юм. Судалгаандаа хэрэгтэй мэдээлэл цуглуулах гэж ярилцлага хийж байх үедээ та өөрийн хувийн итгэл үнэмшил, хэл ярианы акцент, хүйс, нийгэм-эдийн засгийн шинж чанар гэх мэтээ байнга эргэцүүлэн бодох хэрэгтэй болдог. Ярилцагч тань өөрийг чинь хэрхэн хүлээж авч байна вэ, ярилцагч тань таны асуултад хариулахдаа тав тухтай эсвэл эвгүй дургүй байна уу, ярилцагч та хоёрын хооронд хүч, эрх мэдлийн динамик яаж өрнөж байна вэ зэргийг байнга анхаарч байх учиртай юм. Та ярилцагчаа байцааж байгаа аятай нөхцөлд оруулж, өнөөх хүн тань ч таныг “хотоос, гадаадаас ирсэн хүн юм чинь ямар нэгэн зүйл ярьж өгөхгүй бол болохгүй” гэсэн үүднээс харж байвал таны судалгааны чанар тун тааруу л болно. Мөн ярилцагч тань өөрийн бодол санааг ярьж байна уу эсвэл таны сонсохыг хүссэн зүйлийг бүүр эсвэл хэдэн өдрийн өмнө телевизээс үзсэн зүйлээ эргүүлээд ярьж байна уу гэдгийг ч анхаарах хэрэгтэй. “Ярилцагч өөрийн ертөнцийг дүрсэлж буй утга, тайлбар, ойлголтыг ойлгохын тулд маш нягуур анхааралтай сонсох шаардлагатай” (Rubin & Rubin 1995, 7). Тиймээс та ямар нөхцөл байдал, яаж асууж байгаа тань таны мэдээллийн чанарт шууд нөлөөлнө. “Асуулт асуух бол ярилцлага хийх ур чадварын зөвхөн тал хэсэг” (Valentine 2005, 122) гэдгийг санаж, ярилцлагын орчин нөхцөл, утга авцалдааг ч тооцож үзэх хэрэгтэй.

## Угсаатны зүйн судалгаа, шинжилгээ: оролцон ажиглах

Уг арга зүй нь хэд хэдэн хэлбэр байж болно. Жишээ нь, өөрийн ажиглалт дээр тулгуурласан, шууд болон дам байдлыг хослуулсан, олон жилийн туршид үргэлжлүүлэн ажиглан судлах, богино хугацааны, тодорхой сэдэвт баригдсан, багийн (Pink & Morgan 2003,

352) зэргийг багтааж болно. Уг аргыг ашиглан ярилцлага, оролцон ажиглах, нутгийн хүмүүстэй ижилсэх, найзлах, нийгмийн ухааны бусад аргыг хослуулан судалгаа хийж болно. Улмаар угсаатны хээрийн судалгаатай холбогдож буй бүх зүйлийг, цаг хугацааны үе бүхэнд төдийгүй өдөр тутмын амьдрал ахуй, болж байгаа үйл явцыг (Pink & Morgan 2003, 355) судалж болдог. Мөн нийгэмсоёлын онцлог, түүний үндэс суурь шалтгааныг, яагаад бидэнд сонирхолтой байгааг илрүүлэн судлах боломжтой. Тэрчлэн биет болон материаллаг эд зүйлс, бодит амьдрал дээр болж буй бүх зүйлс, яриа, хууч, бичвэр зэргийг ч судалж болно. Ямар нөхцөлд энэ аргыг ашиглавал зүгээр вэ гэвэл бодит байдал дээр суурилсан мэдлэгийн төсөөлөл цар хүрээг гаргах, орон нутгийн мэдлэг тайлбар, дамжиж ирсэн мэдлэгийг бусад баримт бичигтэй уялдуулан дүгнэх, нутгийн, тухайн газар оронд болж буй зүйлд гаднаас нөлөөлж буй зүйлийг тодорхойлох зэрэгтэй ихэд зохицдог арга юм.

## Оролцон ажиглах уу, найзлах уу?

Судалгаанд бэлдэхдээ боломжит статистик, нийгмийн сүлжээ, нутгийн байдал, тулгамдаж буй асуудал, жаргон гээд мэдэж болох бүх зүйлийг мэдвэл зохино. Судлах нутгийнхаа нийгмийн сүлжээний бүлэгт орж, суурь мэдээлэл цуглуулж болно. Тэндээс хүнтэй холбоо тогтоож ч болно. Тэрчлэн байх айлаа ч олох боломжтой. Мөн хэнтэй уулзах, аль нутагт ямар хүмүүстэй, юу ажиглах, ямар түвшинд ажиллах, урьдчилан бэлтгэл хийх хэрэгтэй юу, итгэлцэл хэрхэн бий болгох вэ, судалгааны өдрийн дэглэмээ яаж тогтох вэ гэдгээ ч тооцож байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, урьдчилсан судалгаа гэдэг яг талбар дээрх судалгаанаас дутахгүй том, цаг авсан ажил байдгийг санах хэрэгтэй гэсэн үг. Яг судалгааны талбар дээр ирсэн үедээ аль болох тухайн хүн, соёлын орчинд оролцож, биеэр мэдэрч, яагаад гэдэг шалтгааныг эрж хайж, асууж, бүгдийг тоолж, заримдаа хүмүүстэй хөгжилдөж, сонирхох хэрэгтэй. Ийнхүү өдөржин ажигласан, асуусан, мэдсэн зүйлсээ тэмдэглэ. Мэдээж та тэр өдөр ярилцсан зүйлээ тогтоох ч хожим мартана. Тиймээс мартах зүйлээ зав гармагц, тэр даруй эсвэл орой заавал тэмдэглэ. Өөрөөр хэлбэл, хээрийн судалгаа гэдэг оролцон ажиглах, түүнийгээ тэмдэглэх гэсэн хоёр үндсэн зарчмыг ягштал мөрдөхийг шаарддаг гэсэн үг. Хэдий хугацаанд тэмдэглэл хөтлөх вэ гэдэг тусгай дүрэм байхгүй ч өдөрт хамгийн багадаа хоёр цаг зарцуулбал сайн гэж үзэх нь бий.




**Юу хийж болохгүй вэ?** Яг судалгаа хийж явахад амьдрал дээр янз бүрийн зүйл тохиолдоно. Тантай холбоотой хүндлэлийн асуудал үүсвэл яах вэ. Тиймээс биеэ зөв авч явах хэрэгцээ бий. Заримдаа судлаач гэж өөрийгөө хэт өргөмжлөхөөс сэргийлэх хэрэгтэй. Мэдэмхийрэх, заах, өөрийгөө энэ чиглэлийн мэргэжилтэн, "ингэдэг юм, тэгдэг юм" гэх мэтээр өөрийгөө гайхалтай мэтээр харуулахыг оролдох хэрэггүй. Та тэнд судалгаа хийх гэж очсон болохоос хүндлүүлэх, дайлуулах гэж очоогүй. Таны судалгаанд оролцож буй хүн танд хамаг зүйлээ ярих албагүй тул та тэднийг шахаж, хүчилж болохгүй. Нутгийн заншил ёсыг хүндлэх, бусадтай харьцуулан, "хоцрогдсон, бүдүүлэг" эсвэл "сайн сайхан" гээд байх шаардлага байхгүй. Та тухайн соёлдоо ямар нэгэн байдлаар нөлөөлж болохгүй. Мөн хэн нэгний танд хэлсэн зүйлийг бусдад дамжуулж, янз бүрийн яриа хөөрөө гарах үндэс тавьж болохгүй. Тиймээс тодорхой хувийн болоод мэргэжлийн хил хязгаараа тогтоох ёстой. Мөн бусдыг амьдралыг судлан оролцож байгаагаа зарцлагдаж, дээрэлхүүлж байна гэж бодож, өөрийгөө хохирогч мэтээр сэтгэх хэрэггүй. Та тэр хүмүүсийн тухай их олон зүйл мэдэж авч байгаа. Судлаач та орон нутгийн улс төрд оролцох, нутгархах, талцалд оролцохгүй байх ёстой. Үүний адилаар нэг өрх бүл, айлын үзэл санаанд хэт автах, хайрцаглагдах, түүгээрээ бусдыг нь дүгнэж, үнэлэхгүй байх хэрэгтэй. Мэдээж түмэн шалтаг тоочиж, судалгааны дэглэмээ зөрчих, залхуурах, буцаж ирэхдээ толгой хоосон ирэхээс

сэргийлэх нь чухал. Үүний эсрэг талд судлаач гэдгээ мартан, орчиндоо хэт уусан, ажиглах, учир шалтгаан хайхаа умартаж болохгүй. Үл ойлголцол, сэтгэл хөдлөлтэй холбоотой асуудлыг асууж ярилцалгүйгээр ужгируулах хэрэггүй. Байнга ёс зүйн дүрмээ дахин дахин унших, та тухайн хүмүүстэйгээ найзалж байгаа боловч цаг үргэлжид судлаачаар үлдэнэ гэдгээ санаж байх. Үүний адилаар таныг хүлээж авсан айл, гэр бүл таны нэг хэсэг болсон ч тэд таныг судлаач гэдгийг дандаа санаж байгааг санаарай. Тиймээс та ямагт гадны хүн гэдгээ санаж, хэлэх үг, гишгэх газраа цаг ямагт бодож, биеэ зөв авч явах ёстой.

**Сэдэвтэй холбоотой унших бүтээл**

McDowell, L. 2011. Interviewing: Fear and Liking in the Field. In DeLyser, D., Herbert, S., Crang, M. and L. McDowell (eds). The SAGE Handbook of Qualitative Geography.

Bernard, H. R. 2011. 'Participant Observation', in Research Methods in Anthropology. Lanham: Rowman & Littlefield, pp. 256-290

Blommaert J 2010. Ethnographic Fieldwork: A Beginner's Guide. Bristol: Multilingual Matters.

Crichton, Susan, and Shelley Kinash. 2003. "Virtual ethnography: Interactive interviewing online as method." Canadian Journal of Learning and Technology/La revue canadienne de l'apprentissage et de la technologie 29.2.

Emerson RM, Fretz RI and Shaw LL. 2011. Writing Ethnographic Fieldnotes. University of Chicago Press.

Evans, J., & Jones, P. 2011. 'The walking interview: Methodology, mobility and place.' Applied Geography 31(2): 849–858.

Harvey, W. S. 2010. 'Methodological approaches for interviewing elites.' Geography Compass 4(3): 193–205.

# БҮЛЭГ 5:

## ЯАГААД СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙ ХАМГИЙН ЧУХАЛ ВЭ?

АРИЕЛ АХЭРН,
Г.МӨНХ-ЭРДЭНЭ

## Хичээлийн тухай

Судалгааны ёс зүй гэж юу вэ, түүнд хандах философийн ба институцын хандлага болон судлаач хүн ямар ёс зүйтэй байх ёстой талаар танилцуулна. Энэхүү хичээлээр судалгааны ёс зүй, нийгмийн шинжлэх ухаан дахь ёс зүйн талаар шүүмж хэлэлцүүлгийн тухай үзэх болно. Ингэхдээ тодорхой практик жишээн дээр ёс зүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох талаар ярилцах бөгөөд дараах асуултууд дээр төвлөрч ажиллана. Судалгааны ёс зүй гэж юу вэ? Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцын зөвлөл өгүүллийг зөвшөөрч хүлээн авсан бол судлаач ёс зүйн стандарт журмыг хангалттай мөрдсөнд тооцож болох уу? Судлаач хүн судалгаа хийж бичих, мөн судалгааныхаа явцад тогтоож буй харилцаанд ёс зүйн ямар асуудалтай тулгарч, шийдэх шаардлагатай болдог вэ? Судалгаа нь хүмүүсийн тухай биш, хүмүүсийг оролцуулаагүй тохиолдолд ёс зүйн ямар асуудал гарч болох вэ? Ямар асуудлыг анхаарвaас зохилтой вэ? Хээрийн судалгааны үеэр ямар ёс зүйн асуудал гардаг вэ? зэрэг асуултад хариулах болно.

## Судалгааны ёс зүйд хандах философийн хандлага

“Ёс зүйтэй байна гэдэг нь янз бүрийн ёс суртахуунтай хүмүүсийн хүлээлтийг хүндэтгэх, бие махбодын болон нийгмийн харилцааны сүлжээг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг” (Clifford et al 2016, 58) гэсэн тодорхойлолт бий. Мөн “ёс зүй гэдэг нь судлаачийн үйлдлийг, түүнчлэн тэдгээр үйлдлүүд нь оролцогчид, түүний гэр бүл, судлаач, олон нийтийн судалгааны хэрэглэгчдэд хэрхэн нөлөөлж буйг зөвтгөх үндэслэл юм. Энэ үндэслэл нь зөв, зохистой эсвэл ёс суртахуунд нийцэхүйц гэж” (Lahman et al, 2011, 1398) үздэг судлаачид бий. Ёс зүй гэдгийг энгийн үгээр тайлбарлахын тулд доор зургийг ажиглан аль нэг сонголтыг нь заавал сонгоно уу? Таны эхний сонголт бол ирж яваа галт тэрэгний замыг өөрчлөн таяг тулсан хүнийг дайруулж, бусад таван хүний амийг аврах бол хоёр дахь сонголт нь таяг тулсан хүний амийг аврахын тулд өнөөх таван хүнийг золиослох юм. Харин сүүлийн хувилбар нь гүүрэн дээрээс нэг хүнийг түлхэн галт тэрэгний замыг хааж таван хүний амийг аврах юм. Та алийг нь сонгох вэ? Аль сонголт илүү ёс зүйтэй үйлдэл вэ?



Барууны философид ёс зүйн олон янзын хандлага бий. Уталитарианизм нь бидний үйлдэл бүхэн бүх нийтийн сайн сайхныг нэмэгдүүлэхийн тулд байх ёстой гэдэг бол Эгоизм нь өөрсдийн сайн сайхныг нэмэгдүүлэх ёстой гэдэг. Деонтологи үр дагавар ямар байхаас үл хамаарч зарим зүйлийг хийх нь зайлшгүй үүрэг юм (үнэнийг хэлэх г.м.) гэж үзнэ. Хүний эрхийн үүднээс бол хүн бүр төрмөл заяагдсан эрхтэй бөгөөд нөхцөл байдал ямар байхаас үл хамааран түүний эрхэнд хэн ч халдаж болохгүй гэж сургадаг. Верчу ёс зүй (Virtue ethics) нь юу хийх ёстой тухай биш илүү бид ямар байх ёстой вэ гэдгийг чухалчилдаг. Феминист ёс зүй нь Барууны гүн ухааны уламжлалын хүрээнд эмэгтэйчүүдийг дорд үздэг байсныг эсэргүүцдэг. Харин Экологийн ёс зүй байгаль нь өөрөө ёс суртахууны статустай зүйл бөгөөд хүн төрөлхтөнд яаж нөлөөлөхөөс үл хамаараан түүнийг хамгаалах ёстой гэдэг.

**Деонтологи vs Консекуэнтализм хандлага:** эхний хандлага нь аливаа үйлдлийн шууд үр дагаврыг авч үздэг (жишээ нь, амлалтдаа хүрэхгүй байх). Зарим үйлдлийн мөн чанар нь угаас сайн гэж үздэг. Мөн аливаа зүйл нь сайн мууг тэнцвэржүүлэхгүй байсан ч ёс зүйн хувьд зөв байж болно. Харин хоёрдох хандлага нь муугаас илүү сайныг бий болгож байвал тэр зөв үйлдэл болно гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хор хөнөөлгүй бол буруу биш. Аливаа үйлдлийн үр дагавар нь тухайн үйлдлийн зөв бурууг дэнсэлнэ (тиймээс "зөв"нь заавал „сайн"байх албагүй). Хэрэв ёс зүй нь таны үйлдлийг зөвтгөхийн тулд байдаг юм бол ёс суртахууны үнэмлэхүй хууль, зарчим байдаг уу?

Яг тийм гэж хэлэхэд хэцүү ч олонх дагаж мөрддөг ёс зүйн дүрэм журам гэж бий. Жишээ нь, эрдэм шинжилгээний дүрэм журам, тухайн байгууллагын шаардлага, улс төрийн тогтсон заншил зэргийг нэрлэж болно. Эрдэм шинжилгээний ёс зүйн журмын хувьд тухайн судалгаа хэнд ашигтай вэ, зохиогчийн эрхийг хэн эзэмших вэ, мэдлэгийг хэн эзэмшдэг вэ, үнэхээр зохиогч уу, нэрээ хавсруулагч уу, академик эрх чөлөөний хэмжээ хязгаар юу вэ зэрэг олон асуудлыг багтаасан байдаг. Судалгааны ёс зүйн дүрэмд судалгааны үед тохиолдол асуудлыг ч багтаасан байдаг. Жишээ нь, хээрийн судалгааны үеэр хүмүүсийн хоорондын зөрчлийг хэрхэн шийдвэрлэх вэ, хууль бус үйлдлийн гэрч болбол яах вэ, дээрэлхэл, дарамтлалын гэрч болбол хэрхэн вэ, ашиг сонирхлын зөрчилтэй хүнээс тусламж, санхүүгийн дэмжлэг хүсэх үү, зочломтгой байдал, сайхан сэтгэлийг ашигласан байвал яах вэ зэрэг нарийн, чухал асуудлыг ч багтаадаг.

## Судалгааны ёс зүйн үндсэн зарчим

Ёс зүйн хяналтын олон тогтолцоог үндэслэсэн гарч ирсэн үндсэн зарчим дараах зүйлийг ихэд анхаардаг. Тэдгээр нь нь:

- Шударга ёс - Хэнд ашигтай вэ? Энэ шударга уу?
- Ашиг тус - Бэрхшээл, хор хөнөөлийг арилгах, сайн сайхныг нэмэгдүүлэх
- Хүндэтгэл - Бусдын сайн сайхан, итгэл үнэмшил, өв уламжлал, ёс заншлыг харгалзан үзэх
- Нууцлал - Байгууллагын болон хувийн
- Зөвшөөрөл - Ил тод байдал, судалгаанд оролцсоноор хүлээх үүрэг хариуцлагыг ил тодоор хэлж мэдээлж, зөвшөөрөл авах зэрэг юм.

Судалгааны бүхий л үе шатанд судалгааны ёс зүйг мөрдөх учиртай. Тиймээс судалгааны эхнээс л энэ талыг асуудлыг төлөвлөх, мэдээлэл цуглуулах, бичих, танилцуулах, түгээх зэрэг дээр анхаарвал зохино. Антропологийн судалгааны хувьд судалж буй соёлдоо хөндлөнгөөс нөлөөлж, гэм хор учруулж болохгүй гэсэн суурь шаардлагыг тавьдаг. Тиймээс судлаач та судалгааны хүрээлэн буй орчин, нийгэм, хувь хүн, өөртөө гэх мэт сөрөг нөлөөллийг аль болох бага байлгах хэрэгтэй. Таны судалгаанд оролцох нь төвөгтэй байвал тухайн хүнийхээ ачааллыг бууруулах, бэрхшээлийг арилгахад чиглэсэн ямар нэгэн ажил хийх хэрэгтэй. Мэдээж ямар ч судалгааг зөвшөөрөл авч хийх ёстой. Судлуулж буй хүн тань сайн дураар судалгаанд оролцох зөвшөөрөл

бөглөж, судалгааны талаар сайн ойлголттой, тэд юу хийх ёстой, тэдний мэдээллийг хэрхэн ашиглах талаар, эрсдэл, ашиг тусын талаар тодорхой ойлголттой болсон байх ёстой.

Судалгааны ёс зүйн “San” код гэж дүрэм байдаг бөгөөд тэнд дөрвөн гол үнэт зүйлийг шударга байдал, хүндлэл, санаа тавих, чин сэтгэл хэмээн тодорхойлсон байдаг. Тиймээс судалгааг санхүүжүүлэгчид орон нутгийн иргэд судалгааны бүх л шатанд оролцох боломжоор хангахыг шаардах нь нэмэгдэж байна. Ингэхлээр өнөө цагийн судалгаа нь академик хүрээнээс гадна оролцогч талуудад ашиг тустай эсэхийг тооцож үзэхийг шаарддаг болж байгаа гэсэн үг. Судалгаа нь бодлого боловсруулахад нөлөөлөх төдийгүй нутгийн иргэдийн өмнө хариуцлагатай байх үүрэгтэй болж байна. Харин уламжлалт судалгаа нь тухайлбал, судлаачид мэдээлэл цуглуулчхаад нутгийн иргэдэд үр дүнгээ танилцуулдаггүй байв. Тэрчлэн гадны улсаас ирсэн судлаачид болон нутгийн иргэд хооронд эрх тэгш харилцаагүй, судалгааны ашиг тусыг хуваалцдаггүй байжээ. Өөрөөр хэлбэл, орон нутгийн иргэдийн “шулан мөлжсөн” шинжтэй байсан гэсэн үг.

Магадгүй гадны улсын судлаач судалгаа хийхдээ хэн нэгнээр туслуулсан, орчуулагчаар ажиллуулсан байвал яах вэ? Судалгааны үр дүн болон өгүүлэлдээ тэрхүү туслагчийнхаа нэрийг дурдагдах уу, судалгаанд оролцогч нартаа судалгааны эцсийн үр дүнгээ хуваалцах уу эсвэл тэднийг судалгаандаа яаж дүрслэн харуулснаа нуух уу. “Судалгаанд оролцогч нь судалгааны үр дүнгээс өөрийнхөө амьдралын тухай бодит үнэнийг олж уншина гэсэн хүлээлттэй байхад судлаач нь шал өөр судалгаа хийсэн байж болно. **Энэ асуудлыг зохицуулах нь судлаачийн үүрэг юм**. Судлаач ямар өгүүлэл аль сэтгүүлд хэвлүүлэхээ сайтар бодох хэрэгтэй. Учир нь, судалгаанд оролцогчид өөрсдийнхөө талаар ямар мэдээлэл өгч, өгүүлэлд ямар байдлаар дүрслэгдэх вэ гэдэгт их анхаарч, ач холбогдол өгдөг болсон” (Pickering & Kara 2017, 302) цаг үед бид амьдарч байна.

Ийм учир шалтгааны үүднээс судалгааны байгууллагууд судалгааны тодорхой дүрэмгаргаж, дагаж мөрдөхийг ажиллагсдаасаа шаарддаг болжээ. Жишээ нь, Оксфордын их сургуульд хийгдэж буй бүх судалгаа ёс зүйн хяналт давах ёстой болдог. Ямар ч судалгааны төслийн зорилго, ашигласан арга зүй, цуглуулах мэдээллийн төрөл, мэдээллийг хэрхэн хамгаалж, зохицуулах вэ, оролцогчдоос хэрхэн зөвшөөрөл авсан, оролцогчдод учрах эрсдэл, ашиг тус гэх мэт зүйлсийг нарийн тоочиж, уг шалгуурыг давдаг байна.

Монгол Улсын судалгааны байгууллага, их сургуулиудад энэ талыг дүрэм журам дутагдалтай, байгаа журмаа дагаж мөрдөх нь бага тул судалгааны ёс зүйтэй холбоотой маргаан тасрахгүй байна. Бусдын бүтээлийг эрхийг зөрчих, судалгаа хийхдээ ёс зүйн суурь зарчмыг ч баримтлахгүй байх нь энгийн үзэгдэл болсон гэж болно. Гэтэл эргээд ёс зүйн зөрчилд хариуцлага тооцохгүй байгаа нь энэ гэмт хэрэг, ёс зүйгүй үйлдэл улам гаарах үндэс болж байгаа юм.

Одоо сэдэвтэй холбоотой хоёр асуултад хариулж, ёс зүйн үүднээс ямар асуудал үүсэхийг таамаглацгаая. **Асуулт 1:** Чи ажил дээрээ нэг судалгаанд туслах болов. Судалгааны ахлагч чамд дата анализ хийхийг заая гэхэд чи баяртайгаар хүлээн авлаа. Тэрээр чамд хичээл зааж байх үедээ "ямар үед өгөгдлийг жаахан өөрчлөхөд илүү сайн үр дүн гаргаж болохыг сурах нь хэрэгтэй" гэв. Чи ахлагчийн хэлсний дагуу судалгааны мэдээллээ өөрчлөхийг сурах уу эсвэл ингэж болохгүй гэж хэлэх үү? Чи юу хийх вэ? **Асуулт 2:** Чи Өмнөд Африкийн алслагдмал газарт буй ХДХВ, ДОХ-той айлуудаас мэдээлэл цуглуулах ажил хийж байна. Тэнд чи өвчтэй ээжийгээ асарч байгаа маш туранхай, туниагүй, ДОХ-ын бүх шинж тэмдэгтэй нэг хүүхэдтэй таарлаа. Тухайн нутгийн эмнэлэгт тэр хүүхдийг шинжилгээнд хамруулсан, хариу нь сөрөг гарсан гэж чамд хэлэв. Гэхдээ чи тэдний үгэнд итгэсэнгүй, тэд цусны дээжийг алдсан эсвэл мэдэлгүй сольчихсон гэж хардаж байгаа. Хамгийн ойрхон эмнэлэгт машинаар 4 цаг явж байж хүрнэ. Гэтэл чамд судалгааны төслөө дуусгах маш бага хугацаа үлдсэн байдаг. Үлдсэн цагтаа ажлаа хийвэл чамд өөрт чинь л хэрэгтэй. Мөн чи нутгийн эмнэлэг зэрэг нутгийнхантай сайн харилцаатай үлдвэл ирээдүйд чамд л хэрэгтэй. Чи тухайн хүүхдийг авч ойрын эмнэлэг рүү явах уу, судалгаагаа үргэлжлүүлж хийгээд гэртээ харих уу? Ийм тохиолдолд чи яах вэ?

### Сэдэвтэй холбоотой унших бүтээл


Clifford et al. 2016. Key Methods in Geography. London: SAGE Publication.

Lahman, MKE et al. 2011. Culturally responsive relational reflexive ethics in research: the three rs. Qual Quant 45: 1397-1414.

Pickering, L. and H. Kara. 2016. Presenting and representing others: towards an ethics of engagement. International Journal of Social Research Methodology. 20(3).

Simonsen, J. and T. Robertson. Routledge International Handbook of Participatory Design. Routledge.

# БҮЛЭГ 6:

## СУДАЛГААНЫ АРГУМЕНТ БОЛОВСРУУЛАХ

ТРОЙ СТЕРНБЕРГ

## Хичээлийн тухай

Эрдэм шинжилгээний ажил бичихэд аргумент боловсруулах нь хамгаас чухал. Аргумент нь таамаг дэвшүүлэхээр эхэлж, цаашлаад тухайн таамгийг судалж шинжилж, эцэст нь үр дүнг танилцуулж төгсдөг. Судалгааг ач холбогдолтой, тухайн салбартаа нөлөөтэй болоход хүчтэй аргумент гол үүрэг гүйцэтгэдэг. Аргумент нь судалгааны арга зүй, анализ, дүгнэлтийг хийхэд чиглүүлэгч болж өгдөг. Платон нэгэнтээ “аргумент дүр эсгэх нь олон” гэж хэлсэн байдаг ч судалгаанд аргумент дүр эсгэгч байж хэрхэвч болохгүй. Энэхүү хичээлээр бид хэрхэн аргумент боловсруулах талаар үзнэ. Сайн аргумент боловсруулж судалгаандаа ашиглаж чадсанаар шинэ мэдлэг бүтээхэд хувь нэмрээ оруулж чадна.

## Аргумент боловсруулах

Аргумент нь судалгааны өгүүллийг чинь чиглүүлж өгдөг. Яагаад энэ сэдвийг судлах хэрэгтэй вэ, үүнийг яагаад ийм аргаар судлах нь зөв бэ, яагаад энэ шинжилгээний арга зүй тохиромжтой вэ, өөрийн чинь хийсэн тайлбар дүгнэлт яагаад үндэслэлтэй вэ зэрэг олон асуултад таны аргумент л хариу өгнө. Платон нэгэнтээ “аргумент нь яг хүн шиг, дүр эсгэгч байх нь олон” гэж хэлсэн байдаг. Тиймээс та аргументын хамгийн гол зүйл бол таамаг дэвшүүлэх буюу судалгаагаараа нотлох гэж буй санаа юм гэдгийг анхаарах хэрэгтэй. Тус санаагаа бүтээх нь академик ажлын буюу эссэ, презентац, диссертац, судалгааны өгүүлэл, дипломын судалгааны чухал хэсэг юм. Судалгаандаа дэвшүүлсэн санаа нь сонирхолтой, хүчтэй, няцаахад амаргүй байх ёстой. Ач холбогдолтой, шинжлэх ухааны мэдлэгт хувь нэмэр оруулсан аргументаа илэрхийлээд, баримтаар, нотолгоогоор батлах учиртай.

Тиймээс аргументаа үнэмшилтэй болгохын тулд мэдээлэл, баримт нотолгоо, сурвалж, жишээ зэрэг нотлох баримтаар бататгах хэрэгтэй. Өөрийнхөө санааг судалгаа, шинжилгээгээр бататга. Баримтжуул, эшлэл, ном зүйг сайн хий. Таны авсан жишээ баримт шууд нотлох баримт болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс санаагаа олон талаас бататгах хэрэгтэй. Баримт нотолгоо нь дэвшүүлсэн санааг хэрхэн бататгаж байна вэ гэдгээ байнга нягталж байх хэрэгтэй. Түүнчлэн тус сэдвээр өмнө нь хийгдсэн судалгаа, өөр өнцгөөс бичсэн бүтээлүүдийг судалгаандаа нэгтгэн дурдах нь зүй ёсны хэрэг юм.

**Хайрцгаас гарч сэтгэх** буюу өөр үзэл бодол бий гэдгийг, таны ажлыг няцаах боломжтойг тооцоол. Тухайн сэдвээр өрнөж буй хэлэлцүүлэгт идэвхтэй оролц. Бусдын санааг ойлгож сонс. Өөрийн санаа, арга барилаас давж гаран, илүүг хай. Таны аргументыг бусад судлаач хэрхэн хүлээн авахыг урьдчилан тооцоолж, харахыг оролд. Тиймээс аргумент тань хэт нарийн бус, өргөн хүрээтэй байх хэрэгтэй. Бусад харах өнцөг, концепциудыг анхааралдаа авч, илүү нюанстай аргумент боловсруул. Тиймээс л өөрийнхөө судалгаа, дэвшүүлж буй аргументаа бусадтай хуваалцаж ярилцах хэрэгтэй байдаг.

**Аргумент тань өөрт чинь таалагдах ёстой.** Дэвшүүлсэн аргументаа бусадтай маргахад сонирхолтой байлга, зоригтой бай. Логикийн алдаа гаргахаас болгоомжил. Баримт жишээтэй байлаа гээд шууд нотолгоо болохгүй гэдгийг байнга сана. Жишээ авч буй баримт, нотолгоо чинь яагаад хүчтэй, үнэн зөв гэдгийг тайлбарла. Аргументаа боловсруулахдаа дараах алхмыг дагаж болно. Эхлээд судалгааны асуудлаа тодорхойлох хэрэгтэй. Тус сэдвээр байгаа ном зохиолыг судлан, нэгтгэх, судалгаагаар дэвшүүлэх таамаг, асуулт, зорилгодоо төвлөр. Арга барил, арга зүйгээ анхаар. Үр дүн, баримт нотолгоо цуглуулж, хэлэлцүүлэг, дүгнэлтээ тооцоол. Хэдийгээр эрдэм шинжилгээний бүтээл бүр өвөрмөц өөр боловч нэг гол санааг уншигчдад итгүүлэх, судалгааны үйл явцынхаа бүрэн бүтэн байдлыг хангах, өөрийн аргумент, гол дүгнэлтээ тодорхой илэрхийлэх зорилготой байдаг. Эдгээр алхмыг доор дэлгэрүүлэн тайлбарлая.

**Судалгааны асуудлыг тодорхойлохдоо** ямарваа нэг шийдэлгүй асуудал эсвэл бидний мэдэх ёстой чухал зүйлийг тодорхойлсноор эхэлнэ. Энэ нь судалгааны ач холбогдлыг тодорхойлж, уншигчдын анхаарлыг татаж, судалгаа нь шинжлэх ухааны мэдлэгт ямар хувь нэмэр оруулахыг тодорхойлдог. Жишээ нь: ‘‘Ханбогд сумд нүүдлийн мал аж ахуй, уул уурхай зэрэгцэн орших боломжтой юу?” гэх мэт. Асуудлыг тодорхойлсны дараа л судалгааны нөхцөл, арга зүйг тодорхойлж, үр дүнг хэлэлцэх боломжтой болно. Үүний дараа **таамаг, асуулт, зорилт, зорилгоо** гаргана. Үүнд судалгааны гол асуудлыг, судлах шаардлагатай байгаа зүйлийг тодорхойлох зэрэг багтана. Энэ нь судалгааны таамаг, асуулт, зорилго, зорилт байж болно. Асуудал тодорхой болмогц судалгаа юун дээр төвлөрөх нь ойлгомжтой болж, судалгааны загварыг

тодорхойлж, шинэ мэдлэгийг бүтээдэг. Судалгаа нь ойлголт, мэдлэг, мэдээлэл олгодог. Судалгаагаар ажиглах, харьцуулах, шалгах, шинэ зүйлийг олж нээх боломжтой. Судалгаа бодлого өөрчилж, амьдралыг сайжруулахгүй байж болно. Тиймээс судалгааны зорилгыг тодорхойлохдоо болгоомжтой хандана уу. Платон нэгэнтээ "зөв асуусан асуулт нь зөв хариултаас илүү чухал" гэж хэлсэн гэдэг.




**Судалгааны бүтээлд судлагдаагүй зүйл юу байна хайж ол.** Сонирхож буй сэдвийн чинь талаар өмнө хийгдсэн судалгаанд орхигдсон зүйлийг олж илрүүлбэл сайн. Судалгааны салбарт буй сэдэв, санаанд шүүмжтэй хандаж чадавх та ийм орхигдсон, судалж болох сэдэв олж чадна. Өмнөх судалгааны сул талыг олж, шийдэгдээгүй асуулт, дутуу мэдээлэл, авцалдахгүй байгаа зүйл, онолын уялдаагүй байдал, эсвэл сэдвийг сайн ойлгоогүй байх гэх мэтийг мэдэх нь амжилттай аргумент дэвшүүлэх нэг үндэс болно. Яагаад гэвэл тус сэдэвт хамааралтай судалгааны дүгнэлт, үр дүнг нэгтгэн, судалгааны шинэлэг байдал, ач холбогдлыг тодорхойлж, судалгааны үндэслэлээ хамгаалж, олж нээсэн зүйлээ чухал гэдгийг нотолж чадна гэсэн үг.

**Аргументын бүтэц** ямар байвал зохиолтой вэ? Батлахыг зорьж буй санаа, таамгаа гарга. Одоо нотолгоо буюу дэвшүүлсэн санааг бататгах мэдээлэл, баримт (анхдагч эсвэл хоёрдогч эх сурвалж байж болно) ол. Тэгээд дэвшүүлсэн санаа, цуглуулсан баримт хоорондын уялдаатай байгааг уншигчдад итгүүлэх хэрэгтэй буюу марга. Тиймээс логикийн алдаа гаргаж болохгүй! Учир нь, дэвшүүлсэн аргументыг чинь няцаах, сөрөг аргумент гаргах боломжтой тул бүх талаас нь бодож тооцоолох хэрэгтэй. Эцэст нь дүгнэлт буюу аргумент чинь няцаалтыг давж гарч чадахаар сайн, бат нот байна

уу шалга. Судалгааг цааш үргэлжлүүлэхэд өгөх зөвлөмж, таамаг прогноз бий бол тэрийгээ дурд.

Энэ дундаа **арга зүйгээ мартаж болохгүй.** Судалгааны загварыг гаргахдаа хийх эхний алхам бол яагаад судалгаа хийсэн болно юу хийснээ тайлбарлах явдал юм. Судалгааныхаа зорилгыг дахин сануулж, сонгосон аргазүй чинь яагаад тохиромжтой гэдгийг тайлбарла. Арга зүйтэй холбоотой нарийн ширийнийг тооч - хэн, юу, хаана, хэзээ, яагаад. Ингэснээр уншигч судалгааны загварыг чинь ойлгоно. Цуглуулсан мэдээлэл чинь юуг харуулж байгааг үндэслэн олж нээсэн зүйлсээ тайлбарла. Арга зүй болоод онол нь судалгааны загварыг тодорхойлно. Тиймээс дэвшүүлсэн таамгаа шалгахын тулд мэдээллээ задлан шинжилсэн, хоорондын уялдаа холбоо бий эсэхийг тогтоохын тулд мэдээллийг шинжилсэн гэдгээ харуул.

**Үр дүн, баримт** хэсэгт та үр дүнгээ танилцуулж, баримтаа нэгтгэн эргэцүүлж, хэлэлцэх учиртай юм. Ингэснээр судалгааны асуултад хариу өгч, уншигчдад олж нээсэн зүйлээ танилцуулна гэсэн үг. Судалгаандаа авч үзсэн сэдвүүдийг тодорхойл. Өөрийн арга барил, гол сэдэв, онол, санаа, жишээ, ном зохиол, контекст гэх зэргийг цэгцлээрэй. Энэ хэсэг нь таны судалгааны ерөнхий асуулт эсвэл аргументтай тодорхой уялдаж байх ёстой. Олж нээсэн зүйлсээ ач холбогдол, цаг хугацаагаар нь эрэмбэлж, дэс дараатайгаар бичээрэй. Мөн тэрхүү зүйлс чинь яагаад чухал ач холбогдолтой болохыг тайлбарла. Үр дүнгээ бичих хэсгийн эхэнд гол үр дүн болон аргументаа танилцуулаад, дараа нь цуглуулсан мэдээлэл датагаа танилцуулна. Мэдээллээ хүргэхдээ олж нээсэн зүйл, үр дүнгээ нарийн тайлбарлаж бичээрэй. Мэдээллийг зөвхөн мэдээлэх бус илүү бүтээлч байж, нэгтгэн дүгнэж, тайлбарлаарай. Эхлээд үр дүнгээ танилцуулаад, дараа нь түүнийг бататгасан баримт, датагаа тайлбарлана. Тодорхой, цэгцтэй байж, замбараагүй байдал үүсгэхээс зайлсхий (хэт олон тоо, эшлэл, статистик). Мэдээллээ тайлбарлахдаа дэс дараатай байх, судалгааны үндсэн асуултад ямар ач холбогдолтойг тайлбарлах нь чухал.

Судалгаандаа **дүрс, зураг, хүснэгт, графикийг ямар үед хэрэглэх зохимжтой вэ?** Олон дахин давтаж бичихээс зайлсхийхийн тулд нарийн төвөгтэй мэдээллийг зураг, хүснэгт, график хэлбэрээр үзүүлбэл зүгээр. Гэхдээ тэрхүү зураг, хүснэгт,

график нь ганцаараа хангалттай мэдээлэл агуулж байх ёстой гэдгийг анхаараарай. Зураг оруулахдаа товч гарчиг бичих, дугаарлалт, зүүлт хийхдээ цэгцтэй байх, энгийн бөгөөд тайлбарлахад хялбар (өнгө, үсгийн хэмжээ г.м.) байх гэсэн зарчмыг мөрдвөл сайн.

Бичвэрийн **хэлэлцүүлэг, дүгнэлт** хэсэгт аргумент, болон түүнийг батлахад ашигласан гол баримтаа нэгтгэн дүгнэ. Мэдээллээ нэгтгэж, тайлбарлаж, судалгааны ач холбогдол, үр дагаврыг тайлбарлана. Дүгнэлтийн хэсэг нь аргументын ач холбогдлыг тодруулж, хэлэлцүүлэг хэсгийг нэгтгэж төгсгөнө. Энэ хэсэгт нь арай чөлөөтэй бичиж болох бөгөөд уншигчдад гүн сэтгэгдэл төрүүлэх учиртай. Өгүүлэл нь удиртгал хэсгээс эхлээд хэлэлцүүлэг хүртэлх баримт бичиг, аргументыг хооронд нь холбосон товч тодорхой үгсээр төгсөх ёстой юм.

Дээр зөвлөсөн бүхнээ **товчилбол** бичих гэж буй өгүүлэл, эсвэл диссертацийн бүтцээ сайтар төлөвлө. Аргументыг чинь сайн тодорхойлж өгөх бүтэцтэй байх ёстой. Нарийн ширийн бүхнийг дурдаж, олж нээсэн зүйл дээрээ төвлөр. Бичих нь судалгаа хийх үйл явцын нэг хэсэг мөн. Бичвэрээ хэд хэд засах шаардлагатай болно гэж эхнээсээ төлөвлө. Алдаа мадаг бий эсэхийг сайтар шалга. Алдаагаа олохын тулд найз, багш гэх мэт өөр хүнээр уншуулбал тун нэмэртэй байдаг. Бичвэрийн удиртгалын эхэн, сүүлийн хэсэг, бичвэрийн дунд хэсэг, дүгнэлтийн хэсэгт аргументаа дахин танилцуул. Судалгааныхаа өгүүлэмж дээр төвлөр. Хэрэгцээгүй мэдээлэл бичихээс зайлсхий. Ном зохиол, арга зүй, онолын талаар бичихдээ маш нарийн нямбай бай, тэдгээрийг аргумент, судалгаатайгаа үргэлж уялдуулахын хичээ. Эрдэм шинжилгээний өгүүллийн гол зорилго нь уншигч дэвшүүлсэн санааг тань итгэх явдал юм. Хувийн үзэл бодлоо илэрхийлэх нь илүүц зүйл гэдгийн анхаар. Тиймээс л Платон “магадлалаас гаргаж авсан аргумент үнэ цэнгүй” гэж хэлсэн байдаг.

### Сэдэвтэй холбоотой унших бүтээл

White, P. 2008. Chapter 5: Answering research questions: claims, evidence and warrant. In White, P. Developing Research Questions: A Guide for Social Scientists. Palgrave Macmillian.

Manchester Academic Phrasebook: https://www.phrasebank.manchester.ac.uk

# БҮЛЭГ 7:

## ЭШЛЭЛ АВАХ, НОМ ЗҮЙ ХИЙХ, ОЮУНЫ БҮТЭЭЛИЙН ЭРХ ЗӨРЧИХГҮЙ БАЙХ

АРИЕЛ АХЭРН,
Г.МӨНХ-ЭРДЭНЭ

## Хичээлийн тухай

Зүй зохистойгоор эш татаж, эх сурвалжаа зааж байх нь судлаачийн ёс зүйн чухал хэсэг юм. Судлаач хэрхэн эш татаж, эх сурвалжаа зааж байгаагаар түүний бусдын бүтээлд хандах хандлага харагддаг. Бусдын бүтээлийг ашиглахдаа зохиогчийн нэрийг дурдсанаар түүний хийсэн ажил хөдөлмөрийг үнэлж, хүндэтгэж буй хэрэг болно. Эшлэл, ном зүйг хангалттай сайн хийгээгүй, эсвэл зохисгүй байдлаар ашигласан тохиолдолд бүтээлийн хулгайд тооцогдох боломжтой. Бусдын зохиол бүтээлийг шууд хуулах, эсвэл бусдын санааг өөрийн мэтээр танилцуулах гэх зэрэг бүтээлийн хулгайн олон хэлбэр байдаг. Судалгааны ёс зүйн зарчим, журмыг зөрчих нь судлаачийн карьер, нэр хүндэд маш муугаар нөлөөлдөг. Энэхүү хичээлээр плажиаризм буюу бүтээлийн хулгай, ном зүй, эшлэлийн тухай тодорхойлолтыг танилцуулах болно. Түүнчлэн плажиаризмийн олон хэлбэрийн талаар, мөн эх сурвалжийг хэрхэн зөв  эш татаж, дурдах талаар ярилцана.

## Эшлэл, ном зүй

Плажиаризм (plagiarism) буюу бүтээлийн хулгай гэдэгт бусдын бүтээлээс ямар нэгэн хэмжээгээр хуулах, бусдын бүтээлийг өөрийнх мэтээр хүргэх, зохиогчийн нэрийг дурдахгүйгээр санааг нь товчлон бичих, өөрийн өмнө хэвлүүлсэн зүйлээс хуулбарлах зэргийг оруулж болно. Аливаа судалгааны  ном зүйд судалгаандаа ашигласан санаа, мэдээллийн эх сурвалжийг тусгаж өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, судалгааны  ажлаа бичихдээ уншиж, эш татсан эх сурвалжийг ном зүйд багтаана гэсэн үг. Эшлэл гэдгийг бичвэрийнхээ үндсэн хэсэгт эх сурвалжаа товч эшлэн оруулахыг хэлж байна гэж ойлгож болно. Зохиогчийн эрх гэдэгт оюуны өмчийн хуулиар хамгаалагдсан эрхийг багтаана. Зохиогчийн эрхтэй материал (жишээ нь, зураг) зэргийг ашиглахдаа заавал зөвшөөрөл авах шаардлагатай. Шууд эшлэл гэдэгт ашигласан эх сурвалж дахь үгсийг тэр чигт нь эшлэхийг хэлж байна. Ингэж эшлэхдээ үгсийг хашилтад авч, ардаас нь эх сурвалжийг дурдах ёстой. Дахин бичиж эшлэх (paraphrase) гэж эх сурвалж дахь санааг өөрийн үгээр бичих, аливаа санааг өөрийн үгээр найруулан бичих, ингэхдээ мөн л эх сурвалжийг дурдахыг хэлнэ.

**Яагаад бид ном зүй, эшлэл хийх ёстой юм бэ, зүгээр л хуулаад болоод л байдаг биз дээ?** Үгүй. Энэ нь маш том гэмт хэрэг, ёс зүйгүй үйлдэл. Та энгийн амьдрал дээр хэн нэгний өмчийг зүгээр авчихвал “хулгай” гэх мэт гэмт хэрэгт холбогдоно. Яг түүний адилаар хэн хэний бичсэн нэг үг, өгүүлбэр тэр хүний оюуны өмч байдаг. Тиймээс та бусдын олсон санаа, цуглуулсан мэдээлэлд хүндэтгэлтэй хандах ёстой, үүрэгтэй. Мөн та судалгаа хийхдээ аливаа онол, санаа, концепцийн түүхийг хэрхэн авч үзэж байгааг танд харуулдаг. Эш татсанаар хуучин онолыг цааш хөгжүүлж, шинэ чиг баримжаа бий болгож, шинжлэх ухаанд хувь нэмрээ оруулах эхлэлээ тавьж буй юм.

Манай улсад энэ төрлийн зөрчил газар авч мэргэжлийн болоод мэргэжлийн бус цөөнгүй ном, өгүүллийг сөхөн үзвэл эшлэл зүүлтгүй, арав хүрэхгүй судалгаа ашигласан гэж ном зүйдээ оруулсан байх. Бусдын болоод өөрийн бүтээлээс чөлөөтэй хуулж, хуулбарлан улсын төсвөөс санхүүждэг Шинжлэх ухаан технологийн санд төслийн үр дүн гэж хүлээлгэж өгөх гэх мэт зүйл жирийн үзэгдэл болсон байгаа нь харамсалтай.

**Ямар мэдээллийг заавал эшлэх ёстой вэ?** Ерөнхийдөө та өөрөө ахлан хэлж, бичиж буй биш л бол заавал эшлэх ёстой. Гэхдээ энэ бүхнийг илүү тогтолцоотой болгохын тулд доорх маягаар ангилсан мэдээллийг заавал эшлэх ёстой гэж хэлж болох юм. Тэдгээр нь:

1. Хүснэгт, статистик, диаграм, зураг гэх мэт мэдээллийн эх сурвалжийг дурдахад
2. Тодорхой зохиогч эсвэл зохиогчдын онол, концепц, арга, загварыг дурдахад
3. Өөрийн дэвшүүлсэн аргументыг бусад хэвлэн нийтлэгдсэн судалгаа, материалаар бататгахад
4. Бичсэн ажилд тань хамааралтай бусдын санал нийцсэн эсвэл зөрсөн бичвэрийг дурдахад
5. Аливаа эшлэл, тодорхойлолтыг шууд хуулан буулгахад
6. Бусдын бичсэн ажлыг өөрийн үгээр найруулан бичихэд
7. Өөрийнхөө өмнө нь бичсэн ажлыг дурдахдаа буюу өөрөө өөрөөсөө хуулахаас зайлсхийхийн тулд (Neville 2007, 17) зэрэг байж болно.

Гэвч **бүгдийг мэддэг зүйлийг заавал эшлэх албагүй.** Жишээ нь, "Монгол Улс нь ОХУ, БНХАУ хоёрын дунд оршдог", "дэлхий нарыг тойрч эргэдэг" гэх мэт мэдээллийг заавал хаа нэгтэйгээс эшлэх албагүй. Өмнө дурдсан судалгааны ёс зүй, судлаачийн ёс зүйн хүрээнд судлаач тодорхой үнэт зүйл, зарчмыг даган мөрдөх ёстой байдаг. Тиймээс судлаачийн ёс зүй гэдэг нь судалгаа хийж, бүтээл бичихдээ шударга, хариуцлагатай байхыг шаардаж буй юм. Тэгвэл юуг **судлаачийн ёс зүйн зөрчил гэж үзэх вэ?** Албан тушаалаа ашиглан ямар нэгэн цензур тавих, бусдын бүтээлийг ямар нэгэн хэмжээгээр хуулах, бусдыг дээрэлхэх, доромжлох, шахан хавчих, зүй бус үйлдэл хийхэд хүчлэх, бусдын санааг хулгайлах, бусдын ажлыг ашиглахдаа эшлэхгүй байх зэргийг оруулж болно. Энэ төрлийн зөрчил манай улсад энгийн шахуу болж "дарга нь, багш нь" гэх зэрэг нэрээрээ түрий барин залуу судлаачийн өгүүлэлд зохиогчоор орох явдал байна. Зарим тохиолдолд бүхэл бүтэн салбарыг өмчлөн авч "миний зөвшөөрөлгүйгээр юм хэвлүүлнэ гэж байхгүй" зэргээр авирласан ичгүүртэй тохиолдолд ч гарлаа. Тэр мэт ёс зүйн зөрчлийг нь хүлээн зөвшөөрөлгүй, эсэргүүцсэн нэгнийг янз бүрийн аргаар дарамталж, айлгаж, мохоохыг ил цагаан оролдож байгаа нь энэ мэт ёс зүйн зөрчил хэр газар авсныг харуулж байна.

**Бүтээлийн хулгайн хамгийн түгээмэл хэлбэрт юу юу орох вэ? Шууд хуулах** хэлбэрт вебсайт, эсвэл онлайн судалгааны өгүүллээс шууд хуулах, эшлэхгүй байх. Зураг, гэрэл зургийг хуулах, эх сурвалжийг дурдахгүйгээр, эсвэл зохиогчийн зөвшөөрөлгүй хүснэгт, графикийг хуулах, бусдын бичсэн кодыг хуулах зэргийг оруулна. **Хэсэгчлэн хуулах** хэлбэрт бусдын бүтээлийг өөрийн үгээр бичихдээ маш хөнгөнөөр, бага зэрэг өөрчлөх (жишээ нь, зарим үгийг солих), эх сурвалжийг заахгүй байх зэргийг оруулна. **Өөрөө өөрөөсөө хуулах** хэлбэрт өөрийн бүтээлээс хуулаад, шинэ ажил мэтээр бусдад хүргэх болон өмнө нь бичсэн бүтээлээс эшлэхдээ эх сурвалжаа заахгүй байх явдлыг багтааж болно. **Орчуулгын хуулалт** гэдэгт аливаа бүтээлийг орчуулахдаа эх зохиолын зохиогчийг дурдахгүй байгаа зөрчлийг хэлнэ.

**Бүтээлийн хулгайн сөрөг үр дагавар юу байж болох вэ?** Судлаач таны мэргэжлийн нэр хүнд унана, ажлаасаа халагдах тохиолдол түгээмэл, хэр зэрэг ноцтойгоос хамаарч гэмт хэргийн шийтгэл ч хүлээж болно. Хэрвээ та оюутан бол даалгаврыг тань тооцохгүй байх, сургуулиас хасах, эрдмийн зэргээ хураалгах хүртэл шийтгэлтэй. Тиймээс "бидний өмнөх үе хуулаад зүгээр л байсан" гэх юм уу, "манай улсад үүнийг зохицуулсан дүрэм журам сул тул, айх явдалгүй" гэх зэргээр хөнгөн хийсвэр мунхаглаж, заавал гэмт хэрэг, ёс зүйн зөрчилтэй холбогдох үйлдэл гаргахгүй байхыг хичээх хэрэгтэй.



to the brain for people with smell loss. In a study published in March[5], 785 people in the United Kingdom had their brains scanned twice. About 400 people became infected with SARS-CoV-2 between scans, so the scientists were able to observe structural changes. The people who recovered from COVID-19 showed multiple changes, including markers of tissue damage in areas linked to the brain's olfactory centre. It's not clear why this was the case, but one possibility is lack of input. "When we cut off input from the nose, the brain atrophies," says Danielle Reed, a geneticist at Monell. "It's one of the clearest things we know about taste and smell."

**Treatments in testing**

In the meantime, many treatments are being explored, often in small clinical trials. But it's still early days, so the only thing that most researchers recommend for now is smell training[6]. Participants are given samples of strong-smelling substances to sniff and try to identify, with the aim of driving the restoration of olfactory signalling. However, the method seems to work only with people who have partial smell loss, Reed says. That means it helps about one-third of people who experienced a chemosensory disruption after COVID-19, adds Parma.

To find treatments for everyone else, many researchers are exploring steroids, which reduce inflammation. COVID-19 is known to trigger extensive inflammation, which might

**MAX PLANCK'S CHERISHED AUTONOMY QUESTIONED**

Demoted archaeologist Nicole Boivin calls on the German government to oversee the research society.

**By Alison Abbott**

A former director of one of the Max Planck Society's prestigious research institutes, who says she was unfairly demoted, has called on Germany's research ministry to oversee the society's procedures for misconduct investigations. Six other Max Planck Institute (MPI) directors, some of whom have themselves been investigated or demoted for misconduct, have also told *Nature* that they feel the society's misconduct investigations lack transparency and are affected by bias.

Archaeologist Nicole Boivin at the Max Planck Institute for the Science of Human History in Jena is one of eight MPI directors who are known to have been demoted, or threatened with demotion, after investigations into allegations of non-scientific misconduct, which includes actions such as bullying and harassment. In an open letter published on 8 June, Boivin says that these investigations have been "plagued by allegations of bias, conflicts of interest, and procedural and legal shortcomings".

The run of demotions has led to an atmosphere of fear among MPI directors, says developmental biologist Herbert Jäckle, an emeritus director at the Max Planck Institute for Multidisciplinary Sciences in Göttingen. "They are concerned about how the investigations are going, but afraid to speak out," he says.

Boivin writes in her letter that she was not given the opportunity "to offer any reasonable response, evidence or witness testimony" to anonymous allegations.

The Max Planck Society (MPS) declined to answer specific questions for this article, but in an e-mailed summary of Boivin's case, a spokesperson told *Nature* that the MPS stands by all of its decisions in the affair and that

632 | Nature | Vol 606 | 23 June 2022

## Сэдэвтэй холбоотой унших бүтээл


Neville, Colin. 2016. EBOOK: The Complete Guide to Referencing and Avoiding Plagiarism. McGraw-Hill Education (UK), 2016.

Roig, Miguel. 2006. "Avoiding plagiarism, self-plagiarism, and other questionable writing practices: A guide to ethical writing."

Gilmore, Audrey, David Carson, and Chad Perry. 2006. "Academic publishing: best practice for editors, guest editors, authors and reviewers." European business review.

Pears, Richard, and Graham J. Shields. 2019. Cite Them Right: The Essential Referencing Guide. Eleventh Revised and Expanded ed. London, . Macmillan Study Skills. Web.

UK Concordat to Support Research Integrity: https://www.universitiesuk.ac.uk/sites/default/files/field/downloads/2021-08/Updated FINAL- the-concordat-to-support-research-integrity.pdf

# БҮЛЭГ 8:

# ЧАНАРЫН МЭДЭЭЛЛИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ НЬ

АРИЕЛ
АХЭРН

## Хичээлийн тухай

Чанарын судалгаа хийх явцад гэрэл зураг, дүрс бичлэг, бодлогын баримт бичиг, ярилцлагын транскрипт, хээрийн тэмдэглэл гэх зэрэг маш олон хэлбэр төрлийн мэдээлэл цуглардаг. Мэдээлэлд дүн шинжилгээ өгнө гэдэг нь тэрхүү мэдээллээс ямар нэгэн зүй тогтлыг олж илрүүлэх, түүнийг тайлбарлахыг хэлдэг. Их хэмжээний мэдээллийг хэрхэн цэгцтэй, уялдаа, дэс дараатайгаар шинжлэх вэ? Өгөгдлийг шинжилнэ гэдэг нь яах гэсэн үг вэ? Цуглуулсан мэдээллээс ямар дүгнэлт гарах вэ? Өгөгдлийг шинжлэхэд онол ямар үүрэгтэй байдаг вэ? Энэхүү хичээлээр бид өгөгдлийн шинжилгээний тухай суурь мэдлэг өгч, чанарын өгөгдлийг кодлох арга барилын талаар ярилцана.

## Чанарын судалгааны мэдээллийг шинжлэх нь

Судалгааны загвар болох ерөнхий бүтэц, арга зүй, концепци, эпистемологи үндэслэлийг тодорхойлох, мэдээллээ хэрхэн задлан шинжлэхээ шийдэх нь судалгааны үндсэн хэсэг юм. Та чанарын судалгаа хийх гэж буй бол чанарын олон өгөгдөл цуглуулна гэсэн үг. Тэгвэл чанарын судалгаа гэж юуг хэлээд байна вэ? Нийгмийн үзэгдлийг ойлгох, дүрслэх, тайлбарлах зорилготой судалгааг чанарын судалгаа гэнэ. Үүний тулд та хүн эсвэл бүл хүмүүсийн амьдрал туршлагыг шинжлэх, хүн хоорондын олон төрлийн харилцааны хэлбэрийг шинжлэх, баримт бичиг, соёлын дурсгал, текст, зураг, кино, хөгжим зэргийг шинжлэх шаардлагатай болно.

Чанарын судалгааны мэдээлэл гэдгийг “бидний туршлагын багасгасан хэлбэр” (Bernard et al 2017), “төлөөллийн хэлбэр” (Carusi 2008) зэргээр тодорхойлсон нь байна. Өөрөөр хэлбэл, бид туршлага буюу харсан үзсэн зүйлсээ бичин буулгаснаар чанарын өгөгдөл бүтээж байгаа юм. Жишээ нь, ярилцлагын транскрипт буюу бичвэр хэлбэрт оруулсан байдал, дуу бичлэг, текст, зураг/дүрс бичлэг, хээрийн тэмдэглэл, биет зүйлс зэргийг чанарын судалгааны өгөгдөлд багтааж болно.

Чанарын судалгаа өгөгдлийн хамгийн түгээмэл хэлбэр нь ярилцлага хийсэн дуу бичлэгээ бичвэр болгосон байдал юм. Ярилцлагын бичлэг хийсэн хугацаанаас 4-6 дахин урт хугацаа зарцуулан яг бичлэгийг бичвэр болгодог. Мэдээж мэдээллийн хэлбэрийг өөрчлөх буюу яриаг бичвэр болгож буй тул тухайн ярилцлага хийсэн орчин, хэл, биеийн хэлэмж, ярианы өнгө аяс

алдагддаг. Гэхдээ ямар нэгэн задлан шинжилгээ хийхийн тулд ярилцлагын бичлэгээ заавал бичвэр болгон буулгах албагүй! Өөрөөр хэлбэл, та хангалттай ойлгож байвал ярилцлагын бичлэгээ шууд сонсоод ажиллаж болно. Агуулга, контекстгүй дан транскрипт, бичлэг дээр тулгуурлан тайлбар хийхэд хэцүү. Дискурс/харилцан ярианы шинжилгээ хийхийн тулд яриаг маш нарийн детальчлан бичигт буулгах шаардлагатай байдаг.

Хээрийн судалгааны үеэр судлаач судалгааны дэвтэртээ хаана, яаж, юу хийсэн, юу уншсан, хүнтэй уулзсан ярианы агуулга, ололт амжилт, нөлөө үзүүлсэн юмс, цааш судлах шаардлагатай зүйлсийнхээ тухай тэмдэглэдэг. Хээрийн судалгааны тэмдэглэлдээ оролцон ажиглалтын хамгийн чухал зүйлс, болсон үйл явдал, арга хэмжээний талаар тайлбар хийх, хүмүүсийн хэлсэн зүйлсийг бичиж авдаг. Магадгүй хувийн тэмдэглэлдээ шинэ санаа, цуглуулсан мэдээллийн чанар шаардлага хангах уу, ойлгомжгүй асуудал юу байна, өөр санаа, таамаг дэвшүүлэх эсэхээ бичиж байдаг. Энэ бүхэн хүртэл чанарын судалгааны өгөгдөл, мэдээлэл юм.

## Өгөгдлийг шинжлэхдээ яг юу хийдэг вэ?

Тоон болон чанарын өгөгдлийг шинжлэхдээ бид **зүй тогтол, сэдэв хайдаг**. Өөрөөр хэлбэл, тэрхүү бичвэрт ямар утга санаа байгаа вэ түүний дагуу ангилал хийх нь үр дүнтэй гэсэн үг. Өгөгдлийг зохион байгуулалтад оруулахдаа ангилах, хайх, цэгцлэх ажлыг хийдэг бол өгөгдлийг тайлбарлахдаа дахин өгүүлэх, танилцуулах, кодыг тайлдаг. Задлан шинжилгээ нь ярилцлага хийхээс өмнө баримт бичгийг шалгах, ярилцлага хийх, хээрийн тэмдэглэл бичих үед эхэлж болно. Ингэснээр шинэ асуудлыг олж илрүүлэх боломжтой болдог. Задлан шинжилгээ бол “өгөгдлөөс зүй тогтол хайж, тэрхүү зүй тогтол яагаад тэнд байгааг тайлбарлах” (Бернард 2006) юм.

| **Дараах зүйлсийг байгаа эсэхийг хар** | |
|---|---|
| Давтамж | Дахин дахин гарч ирж байгаа концепци |
| Тухайн нутгийн хэв маяг/ категориуд | Хэлц үг/ нутгийн онцлогтой үг хэллэг |
| Метафор, аналоги | Тодорхой утгыг тайлбарлахад хэрэглэгддэг |
| Шилжилт | Агуулгад өөрчлөлт гарах нь шинэ сэдэв гарч ирж буйн илрэл |
| Ижил төстэй ба ялгаатай зүйлс | Ижил төстэй ойлголтуудыг сэдвээр ангилах боломжтой юу? |

| | |
|---|---|
| Хэл зүйн холбогчид | Холбоотой зүйлсийг олж тогтоо: өмнө нь/дараа нь; яагаад гэвэл; цаг хугацааны дараалал |
| Дутуу мэдээлэл | Чимээгүй болж дуугаа хураах; эсвэл тодорхой мэдээллийг 'бүгд мэддэг' гэж үзээд дурдахгүй өнгөрөх боломжтой |
| Онолын холбогдолтой материал | Өргөн хүрээний онолтой холбогдох санаа оноо, судалгааг дурдах |

**Бичвэр, текстийг боловсруулж шинжлэхэд** хасах, ангилах арга ашиглагддаг. Чухал үгсийг (exemplar) олж тодруулаад, хоорондоо авцаалдаатайг нь нэгтгэ. Нэгтгэсэн зүйлсээ дэд-сэдвүүдэд хувааж ангилаад, хоорондын уялдаа холбоод тэмдэглэ. Өөрөөр хэлбэл, энэ аргын зорилго нь аль болох олон сэдэв ол. Тэр сэдвүүдийг эрэмбэл. Гарч ирсэн жишээгээ ялган ав. Өөр нэг арга бол **кодлол** юм. Энэ аргыг өгөгдлийг цэгцэлж, зохион байгуулах түүнчлэн тайлбар, онол нэмэх арга гэж болно. Тиймээс ч зарим судлаач "текстийн талаарх сэдэвчилсэн санааг бий болгохын тулд текстийг индексжүүлэх, ангилах арга" (Gibbs 2003) гэсэн байдаг. Код нь өгөгдлийг бэлгэдэх эсвэл 'орчуулах' гэж судлаачийн бий болгосон зүйл юм. Тиймээс "код нь өгөгдлийн нэгж бүрд утга оноодог бөгөөд түүнийг дараа нь паттерн буюу давтамжийг илрүүлэх, категорид ангилах, онол боловсруулах гэх мэт шинжлэх үйл явцад ашигладаг" (Saldana 2015) арга юм.

**Кодлох арга** янз бүр байж болох ч паттерн буюу давтамж илрүүлэх нь чухал. Өөрөөр хэлбэл, таны кодлох гэж буй тэр бичвэрт ямар утга олон давтагдаж байна вэ тэр л тухайн текстийг төлөөлөх код болох боломжтой. Жишээ нь: "энэ улсад хууль бус цагаачдыг багтаах газар байхгүй. Энэ гэмт хэрэгтнүүдийг цуглуулж байгаад хаанаас ирсэн тэр газар луу нь буцааж явуул" (Saldana 2015) гэсэн бичвэр байя гэж бодоцгооё. энэ текстийг яаж кодолж болох вэ? "Газар байхгүй", "Цагаачлалын асуудал", "цагаачдаас айх айдас (Xenophobia) гэж болно. Эргээд тэрхүү код - түлхүүр үгээрээ тухайн мэдээллийг маш хурдан хайж олох боломжтой болно. Мөн адил кодтой бичвэр - текстээ нэгтгэн ямар давтамж гарч байна, тэрхүү давтамж юуг өгүүлж байгааг задлан шинжлэх боломжтой.

Мэдээж өөр олон янзын арга бий! **Кодлол нь мөчлөгтэй явагддаг үйл явц юм.** Кодлол бол зүгээр нэг механик үйлдэл бус - харин өгөгдлөө санаатай уялдуулах арга юм. **Кодлолын зарим аргыг** доор маягаар ангилж болно. Тэдгээр нь:



(Saldana 2015)

1. Descriptive coding: ерөнхий гол сэдвийг хураангуйлдаг
2. Process coding: ямар нэг үйл хөдлөлийг илэрхийлэх үг хэллэг
3. In vivo coding: оролцогчийн өөрийн үгийг ашиглах
4. Pattern coding: өгөгдөл дэх паттерныг илрүүлэх
5. Simultaneous coding: нэг текстэд олон кодлолыг хэрэглэх зэрэг юм.

Нийгмийн амьдрал дөрвөн хэмжээсэнд өрнөдөг гэнэ. Тэдгээр нь "нэг ба түүнээс дээш **оролцогч** тодорхой **цагт**, тодорхой **газар** нэг ба түүнээс дээш **үйл хөдлөл** хийдэг" (Saldana 2015) гэдгээс харагдана. Тэгэхээр **нийгмийн зохион байгуулалтын нэгжийг** доорх маягаар жагсааж болох нь:

1. Соёлын үйл ажиллагаа (өдөр тутмын зан үйл)
2. Тохиол (урьдчилан тооцоолоогүй, эсвэл тогтмол бус тохиолдох үйл явдлууд: салалт, аварга шалгаруулах тэмцээн, байгалийн гамшиг)
3. Учраа (2 ба түүнээс дээш хүмүүс хоорондын харилцаа: худалдан авалт, гуйлга гуйх)
4. Дүрүүд (оюутан, ээж, үйлчлүүлэгч) болон нийгмийн зүйл (дээрэнгүй хүн)
5. Нийгмийн болон хувийн харилцаа (эхнэр нөхөр хоёр, шоучид)
6. Бүлэг, бүлэглэл (гэмт бүлэг, гэр бүл, сүмийн цуглагчид, тамирчид)
7. Байгууллагууд (сургууль, түргэн хоолны газар, ресторан)
8. Суурьшил газар, орчин (тосгон, хөрш зэргэлдээ газар)
9. Дэд соёл, амьдралын хэв маяг (гэр оронгүйчүүд, халзан толгойтнууд) (Saldana 2015) зэрэг юм.

Кодлол гэдэг нь танин мэдэхүйн утга (идеологи, дүрэм журам, концепц, ижилсэл) юм. Мөн сэтгэл хөдлөлийн агуулга буюу мэдрэмж (замын хөдөлгөөн дэх уур уцаар, ажил дээрх сэтгэл хангалуун байдал) ч орно. Түүнчлэн шатлан захирсан тогтолцооны агуулгатай буюу тэгш бус байдлыг (төрхтөөр ялгаварлагчдад, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд) ч багтааж байдаг. **Кодлох үедээ өөрөөсөө байнга** хүмүүс юу хийж байна вэ? Юуг хийж бүтээхийг хүсэж байна вэ? Яг яаж хийж байна вэ? Тэд ямар тодорхой арга барилыг хэрэглэж байна вэ? Болж буй үйл явдлыг хүмүүс юу гэж ярьж, ойлгож, тодорхойлж байна вэ? Энд юу болж байна вэ? Энэ тэмдэглэлүүдээс би юуг ойлгож авч байна вэ? Би яагаад ийм тэмдэглэл хийв? Юу намайг гайхшируулав? Юу миний сонирхлыг татав? Юу миний санааг зовоов? гэх мэтийг асуух байх хэрэгтэй. Ингэж байж код тань илүү утгатай, кодлосон мэдээлэл тань задлан шинжлэхэд илүү хялбар байх болно.

Мөн кодлол, жагсаалт бүтээхдээ тайлбар, жишээ бүхий кодуудыг хадгалах хавтас ашиглаж болно. Ярилцлагаас юуг олж мэдэх боломжтой вэ? Ажиглалтын болон контекстийн ямар нэмэлт мэдээлэл хэрэгтэй вэ? Бүхнийг кодлох боломжтой юу эсвэл үгүй гэдгээ ч тунгаах хэрэгтэй болно. Нэгэнт дээрхийн маягаар кодлогдон цэгцэд орсон мэдээллийг та дараа дараагийнхаа судалгаанд маш хялбараар ашиглаж болно. Жишээ нь, та энэ жил монголын малчдад тохиолдсон зудын тухай их хэмжээний мэдээлэл цуглуулснаа кодлон, цэгцэд оруулан хадгалжээ гэж үзье. Магадгүй хэдэн жилийн дараа та дээрх сэдвээр дахин судалгааны ажил бичих, хэвлүүлэх хэрэгтэй боллоо гэхэд өнөөх мэдээллээ кодоороо хайж олон урьд тохиолдсон зуд ямар байдалтай байсныг санаж, сая хийсэн судалгааны өгөгдөлтэйгөө харьцуулан, задлан шинжилж ямар нэгэн аргумент боловсруулах боломжтой болно гэсэн үг. Тиймээс л зохион байгуулалтгүй, зах замбараагүй мэдээлэл төөрөхгүйн тулд кодлол хийдэг байх нь. Кодлол сайтай өгөгдлийг ч эргээд задлан шинжлэхэд амар байдаг байна.

### Сэдэвтэй холбоотой унших бүтээл

Bernard et al. 2017. *Analyzing Qualitative Data, Systematic Approaches*. London: SAGE Publications.

Carusi, A. 2008. “Data as representation: Beyond anonymity in e-research ethics.” *International Journal of Internet research ethics* 1.1: 37-65.

Saldaca, J. (2015). *The Coding Manual for Qualitative Researchers*. London: SAGE Publications.

# БҮЛЭГ 9:

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧВЭР ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

ТРОЙ
СТЕРНБЕРГ

## Хичээлийн тухай

Академик бичлэг нь бичлэгийн өвөрмөц хэлбэр тул нэлээд дадлага, туршлага шаарддаг. Энэхүү хичээлээр бид академик зохиол бүтээлийн талаар ярилцаж, академик бичлэгт анхаарах гол зүйлүүдийг тодорхойлж, судалгааны хураангуй бичихийг заана. Академик бичлэг нь тухайн ажлыг уншигчдад шинэ мэдлэгийг хүргэх учиртай. Тиймээс бид бүтээлийн зорилго, хэрхэн аргумент дэвшүүлэхийг, жишээ, нотолгоо, шинжилгээгээ тодорхой ойлгомжтойгоор тайлбарлах, судалгааны ажлын бүтэц зэргийг анхааран үзнэ. Судалгааны хураангуй, эсвэл шүүмж бичиж сурснаар эрдэм шинжилгээний өгүүлэлд бүтээл бичиж хэвлүүлэх үйл явц юу болох талаар ойлголттой болно. Ингэснээр академик бичлэгт гардаг бэрхшээлийг ойлгож, бүтээл бичихдээ илүү итгэлтэй, зоригтой болох юм.

## Академик бичлэг

Эрдэм шинжилгээний буюу академик бичвэр нь шинэ мэдлэг бүтээдэг, шинжлэх ухааны хэлэлцүүлэгт хувь нэмэр болж, мэдлэгийг нэгтгэдэг, дэвшүүлж буй санааныхаа үндэслэлийг гаргаж өгдөг, гадаад дотоодын академик хүрээнд уншигддаг өгүүлэл болон хэвлэгддэг, судлаачийн нэгэн төрлийн дуу хоолой болдог (Macdonald 1994) зүйл юм. **Аргумент боловсруулах хэсэгт** үзсэн шиг эрдэм шинжилгээний бичлэгийн гол зүйлсийн нэг нь аргумент юм. Та аргументаараа бусад судлаачтай харилцаж, өөрийн дэвшүүлсэн санааг илүү ойлгомжтой болгож, уншигчдаа татна. Аргумент боловсруулах гэдэг нь өмнө нь тухайн сэдвээр хэвлэгдсэн судалгааг тоймлож, дэвшүүлсэн санааг чинь бататгах баримтыг танилцуулахыг хэлж буй билээ. Тиймээс тодорхой, шулуухан бичих хэрэгтэй буюу өгүүллийн тань эхний догол мөрийг уншихад л дэвшүүлсэн аргумент нь тодорхой байх ёстой.

Судалгааны ажил нь тухайн салбарын бусад судалгаатай уялдаатай байх ёстой шиг тодорхой, ойлгомжтойгоор дэвшүүлсэн аргумент судалгааны бүтцийг тань бий болгоно. Бичих гэдэг суралцах, эргэцүүлэх, бүтээлч үйл явцын нэгэн хэсэг (зүгээр л бодлуудаа бичихтэй адилгүй) тул эшлэл нь тогтсон баримт факт болон бусдын хийсэн судалгааг илэрхийлэх үүрэгтэй юм. Бичих

нь нэр төрлийн харилцаа, нийгэмд оролцох үйлдэл буюу академик хүрээний хүмүүстэйгээ харилцаж байгаа хэрэг болно. Тиймээс тодорхой, ойлгомжтой шулуухан хэлбэрээр бич. Хэт их онолч, өвөрмөц байх гэж хичээх хэрэггүй. Сэтгүүл зүйн бичлэгийн хэв маягаас зайлсхийх хэрэгтэй. Гэхдээ энгийн бай, хэт төвөгтэй болгох хэрэггүйтэй адил бичих гоо зүйн талаа мартаж болохгүй. Үнэн зөв баримт мэдээллийг танилцуулахаас гадна үндэслэлтэй, болгоомжтой байж, өөртөө шүүмжлэлтэй ханд. Дэвшүүлсэн санаагаа нотол. Хамгаалж чадахгүй дүгнэлт хийх гэж яараад хэрэггүй. Аль болох мэдлэг бүтдэг, бий болдог зүйл гэдгийг санаж, бидний гаргадаг арга, үнэ цэн, өрөөсгөл ойлголт, шийдвэрийнхээ үр дагаврыг тунгаан бодох хэрэгтэй. Судлаачдын хувийн улс төр, соёл, нийгмийн нөхцөл байдлын талаар мэдэж байх шаардлагатай. Олон арга, мэдээллийн эх сурвалж/онолын арга барилыг ашиглаж найдвартай дүгнэлт гаргах нь чухал. Мэдээлэл олох боломжийг давхар шалгаж байгаарай. Судалгааны ажлаа эхлүүлснээс хойш шинээр нийтлэгдсэн зүйл бий эсэхийг нягтлан хардаг байх нь чухал юм.

**Параграфийн буюу догол мөрний бүтцийг** олон янзаар зохион байгуулж болно. Гэхдээ ерөнхийдөө гол санаа дэвшүүлээд баримт жишээ ав, тайлбарла. Санаагаа тодорхойл илэрхийлээд бататгах баримтаар тайлбарлах нь хамгийн үр дүнтэй арга юм. Ингэхдээ санаа тань дэвшүүлсэн аргументдаа яаж хувь нэмэр болж, судалгааны асуултад чинь хариулж байна вэ гэдгээ бодолцох хэрэгтэй. Дараагаар нь судалгаандаа үнэлгээ өг, өргөжүүл, шинийг олж мэд, чиглүүлж, зааварла. Бичвэр тань уншигчийг хөгжөөх бус мэдлэг түгээх зорилготой гэдгээ сана. Өмнө дурдсанчлан **тодорхой, ойлгомжтой аргумент боловсруул.** Хүмүүст ямар санаа хүргэмээр байна вэ, уншигч чинь хэн бэ, сэтгүүл зүйн хэв маягтай байж болох уу, баримт байна уу гэх мэт суурь зүйлсээ байнга анхаар. Цөөн үгтэй богино өгүүлбэрээр бичээд нэгэнт бичсэн зүйлээ олон дахин давтах хэрэггүй. Удиртгал, дүгнэлтээ хэлэлцүүлэг хэсэгтээ холбож уялдуулбал сайн. Эшлэл нь аргументын суурь болдог, ач холбогдолтой зүйл тул аль болох сүүлийн үеийн судалгаа байх ёстой. Судалгааны хураангуй өгүүллийн чинь товчилсон хувилбар тул чухал зүйлс болох арга зүй, судалгаа, үр дүн зэргээ товч дурдаад ав.




## Хөндлөнгийн үнэлгээ

Эрдэм шинжилгээний бичвэрийг эрдэм шинжилгээний болгодог зүйлийн нэг нь хөндлөнгийн үнэлгээ юм. Хөндлөнгийн үнэлгээгүй хэвлэгдсэн зүйлийг эрдэм шинжилгээний судалгаа гэж үздэггүй. Хөндлөнгийн үнэлгээ гэж тухайн сэдвээр мэргэшсэн мэргэжилтнүүд, судлаачид таны өгүүллийн нооргийг уншаад юу дутуу судалсан, ямар алдаа мадаг байгааг хэлэх улмаар тухайн сэтгүүлд хэвлэж болох болохгүйг шийдэж буйг хэлнэ. Тэд юу гэж үнэлж буй санал сэтгэгдлээ хэлж, өгүүллийг нарийвчлан үнэлнэ. Түүн дээрээ үндэслэн сэтгүүл өгүүллийг чинь авах, засварлах эсвэл татгалзах эсэхээ шийднэ. Мэдээж таны өгүүллийг судалгаа, бичлэгийн хэлбэр, дүрс баримт, бүтэц гэх зэрэг талаас хэрхэн сайжруулж болох талаар саналаа хэлнэ. Ийм хөндлөнгийн үнэлгээгүйгээр өгүүлэл хэвлэдэг сэтгүүлийг Ангууч сэтгүүл (**Predatory journals**) гэдэг. Ийм сэтгүүл хэвлэлийн төлбөр шаардах нь ч бий. Тиймээс өгүүллээ илгээхээс өмнө хэвлэлийн ямар нэгэн хөлс төлөх шаардлагатай эсэхийг нягталж байгаарай. Өгүүллийг чинь үнэгүй хэвлэдэг сэтгүүл бий боловч сүүлийн үед олон сэтгүүл төлбөр авдаг болсон. Тиймээс хуурамч сэтгүүлээс болгоомжил!

Бодитой, хэрэгтэй, амьдралтай байх үүднээс хэн нэгний бус, өөрийн аргументыг дэвшүүлдэг бай. Уншигч таны судалдаг нутгийн контекст, нөхцөл байдлын талаар ямар ч ойлголтгүй тул энгийн ойлголт өгөх байдлаар тодорхой бич. Зураг, хүснэгт ашиглавал мэдээлэл бүр л ойлгомжтой болдог. Магадгүй уншигч газрын зургаар контекстийг илүү сайн ойлгодог байж болно. Дүрмийн алдаа, үгийн сонголт, урт өгүүлбэрийг анхаарч хянах ч гэсэн таны ажил. Эх хэлээрээ бичээгүй бол заавал тухайн хэлний хүнээр хянуулаарай. Эшлэл, зүүлт, эх сурвалжийг заахдаа тухайн сэтгүүлийнхээ тогтсон аргаар хийдэг гэдгийг мартаж болохгүй. Энэ ч гэсэн хэвлэлийн нэгэн шаардлага гэж явдаг юм. Гэвч энэ шаардлагыг олох амархан. Тухайн сэтгүүлийнхээ вебсайт руу орж үзэхэд л болдог.

**Оюуны хулгай хийж болохгүй**. Монголд болдог байж болох ч олон улсад болохгүй. Та шууд бүтэлгүйтнэ. Учир нь, олон улсын сэтгүүлүүд бүтээлийн хулгайг шалгадаг программтай байдаг. Тиймээс та хурдан баригдана. Хуулан бичлэг зэрэг ямар нэгэн оюуны хулгайн шинжтэй зүйл хийлээ л бол та амархан баригдана. Үнэндээ энэ бүхэн нь дэлхий дахины стандарт болсон байдаг ч манай улсад хэрэгжихгүй байгаа нь харамсалтай. Гэвч манай улсад болдог, хариуцлага тооцдоггүй гээд, өөрийн "муухай зуршлаа" даган хуулж, хуулбарласан бичвэр, өгүүллээ олон улсын хэмжээний сэтгүүлд илгээвэл таны мэргэжлийн нэр хүндэд тун аюултай. Олон судлаач мэргэжлийн ёс зүйгээ эрхэмлэн, бусдын оюуны бүтээлийг хүндэтгэж байхад та заавал цөөнх болсон хэсэг бүлэг, бүтэлгүй улсын муухай жишгийг даган, өөрийн карьертаа хар толбо үлдээх хэрэг юун.

Энэ бүлгийн дүгнэлт болгож **өгүүллийн хураангуй бичих дасгал** хийцгээе. Өөрийн судалгааны сэдвийн дагуу өгүүлэл бичих гэж байна хэмээн төсөөлж (эсвэл бичиж буй өгүүлэл тань ч байж болно) хураангуй бичнэ үү. Хураангуй тань 140-180 үгээс хэтрэхгүй, өгүүлбэр бүр наймаас дээшгүй үгтэй, өгүүллийн агуулгаа бүрэн багтаасан, арга зүй, ямар судалгаа хийсэн, ямар үр дүн гарснаа танилцуулах ёстой.

# БҮЛЭГ 10:

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧВЭРИЙН БҮТЭЦ

АРИЕЛ АХЭРН,
ТРОЙ СТЕРНБЕРГ

## Хичээлийн тухай

Хэлен Суорд (2012) "Stylish Academic Writing" хэмээх номдоо Жозеф М.Виллиамсийн "бид уншигчдынхаа өмнө маш нарийн нюанстай зохиол бичих ёс зүйн үүрэгтэй" гэх үгийг эш татан авсан байдаг. Санаагаа ойлгомжтой тодорхой, уншигч нь төвөггүй ойлгохуйц бичих нь академик бичлэгт хамгаас чухал боловч судлаачид үүнийг мартаж этгээд үг хэллэг, урт ярвигтай өгүүлбэр бичиж уншихад төвөгтэй болгох тохиолдол олон бий. Энэ хичээлээр бид академик бичлэгийн бүтцийг тодорхойлж болох олон арга замыг танилцуулна. Нарийн, ярвигтай санааг цаасан дээр хэрхэн ойлгомжтой цэгцтэй, амархан ойлгогдохуйц байдлаар бичиж сурахын чухлыг бид онцгойлон авч үзнэ. Үүнийг сурахын тулд маш их унших, бас байнга бичиж дадаж, бичгийн арга барилаа сайжруулах хэрэгтэй.

## Эрдэм шинжилгээний бичвэрийн бүтэц

"Өгүүлбэр хүчтэй байх тусам богино байдаг. Тиймээс товчлол бол эрч хүчний дайвар бүтээгдэхүүн юм" (Strunk & White 2007) гэсэн эшлэлийг энд татмаар байна. Эрдэм шинжилгээний бичвэр гоё ганган байхаасаа илүү ойлгомжтой байх хэрэгтэй. Гэтэл олон судлаач энгийн хийгээд суурь дүрэм болох энэ шаардлагаа мартах нь бий. Тиймээс л "ихэнх уншигчийн сайн гэж үздэг зүйл болоод судлаачдын бичиж хэвлүүлсэн судалгаа хоёрын хооронд асар их зөрүү байдаг" (Sword, 2012, 3) гэдгийг судлаачид сануулсаар байгаа юм. Тиймээс танд ойлгомжтой байсан ч гэсэн өөр бусдад ойлгомжгүй байхын бодолцон энгийн, ойлгомжтой бичиж дадаарай.

Ингэж бичиж сурахад жаахан дадлага бас дараах хэдэн асуултыг байнга бодож байхад л хангалттай. Тэдгээр нь: та эрдэм шинжилгээний судалгааны гол зорилгыг юу гэж ойлгож байна вэ, тэрхүү судалгааг тань унших уншигч хэн бэ, судалгааны бүтээл бичихэд ямар бэрхшээл тулгарч болох вэ зэрэг юм. Магадгүй монгол эрдэм шинжилгээний ертөнцөд академик бичлэгийн дэг сургууль, хэв маяг байдаг байж болно. Лавтай англи хэлээр бичдэг Барууны хэв маягаас өөр байж болох юм. Илүү их яруу найраг, хэлц үг, зүйрлэл, дүрслэл ашигладаг, хэлэх гэсэн санаагаа хамгийн сүүлд хэлдэг гэх мэт байж болно.




Харин Барууны эрдэм шинжилгээний бичлэг нь тодорхой, ойлгомжтой, задлан шинжилсэн байдлаар бичихийг шаарддаг. Хэрхэн ингэж бичиж сурах вэ? Хамгийн үндсэн шат бол унш, унш, бүүр их унш юм. Та сайн бичсэн судалгааны бүтээлийн уншиж байж л сайн бичлэг гэж юу болохыг ойлгоно. Улмаар тэндээс авах зүйлийг авч, хаях зүйлийг хаяж даган дуурайж, дахин дахин бичиж байж сайн бичдэг болно. Өнөө цагт судалгааны сайн бүтээл олох бүрэн боломжтой болсон. Шагнал хүртсэн академик судалгаа, ном, өгүүлэл, нийтлэл унш. Уншсаныхаа дараа бич, бич, бас дахин бич. Туршлагатай судлаач хүртэл “би одоо болтол бичихэд суралцсаар л байна” гэж зоригтой хэлэх нь олонтоо. Тиймээс та бичихээсээ айх, халгах, зугтаах хэрэггүй. Бичих нь маш их цаг хугацаа, чармайлт, хичээл зүтгэлийн үр дүнд бий болдог ур чадвар юм. Мөн онцгой, чухал, сурч болдог ур чадвар юм. Та бичсэн зүйлээ мэргэжил нэгт нөхөд, багш нартаа уншуулж, саналыг нь асуу, бүтээлч шүүмжийг нь сонс.

Энэ хичээлтэй холбоотой жижигхэн **бичих дасгал** хийцгээе. Судалгааны төсөл эсвэл өгүүлэлдээ гарчиг бодож ол. Гарчиг чинь 10-аас дээшгүй үгтэй байх ёстой. Уншигчийн анхаарлыг шууд татахуйц байх хэрэгтэй. Өөрийн чинь судалгааны үндсэн санаагаа тод томруун гаргах ёстой. Яг үүний адилаар 8-аас илүү үггүй өгүүлбэр бичих гээд үз. Энэ маягаар 8-аас илүү үггүй 3-5 өгүүлбэртэй нэг догол мөр үүсгэ. Нэг догол мөр нэг л утга агуулж байх ёстойг сана. Өмнөх бүлэгт үзсэн шиг догол мөрний чинь эхний өгүүлбэр юу хэлэх гэж буйгаа шууд хэлсэн, энгийн өгүүлбэр байх хэрэгтэй. Үлдсэн 1-2 өгүүлбэрт яагаад тэгж хэлж буйгаа баталсан баримт, жишээ, мэдээллээ багтаа. Харин сүүлийн 1-2 өгүүлбэр нь тэр бүхнээ илүү дэлгэрүүлж тайлбарласан байвал зохионо.

**Гэвч бид өгүүлэл бичих талаар ярьж байгаа биш билүү?** Тиймээ. Та бүтэн өгүүлэл бичихийн тулд өөрт байгаа дата, өгөгдлийн шинжилгээнээсээ эхлэх хэрэгтэй. Судалгааны гол сэдэв чинь юу вэ? Тэр чинь академик зохиолтой яаж уялдаж байна вэ? Мэдээлэлд чинь холбогдох гол чухал ном судалгаа юу билээ, үндсэн аргументаа ямар байна гэж төсөөлж байгаа билээ гэх мэтээ тооцоолох хэрэгтэй.

Аль хэсгээ эхэлж бичихээ шийдэх нь заримдаа их чухал төдийгүй ажлыг хөнгөвчлөх нь бий. Зарим хүн шууд судалгааны мэдээ баримтын хэсгээ эхэнд бичдэг. Зарим нь удиртгал, судлагдсан байдлын тоймоос эхэлдэг. Тиймээс яг энэ хэсгээсээ эхэлбэл зүгээр гэсэн алтан дүрэм байхгүй. Та өөрөө шийднэ. Гэхдээ та судалгаагаа хэвлүүлэхийг хүсэж буй сэтгүүлийнхээ шаардлага, өмнө хэвлэгдсэн өгүүллийн бүтцийг нь шалгаарай.

**Англиар бичих** бол үйл үгийн идэвхтэй төлөв дээр бичих хэрэгтэй гэдэг. Идэвхгүй хэвээр бичих нь тийм ч сайн сонголт биш. Өгүүлбэр бүрд эзэн бие, үйлдэгдэж буй үйлдэл, үйл үг тодорхой байх ёстой. Хэрэв тэдгээр нь тодорхойгүй бол өгүүлбэрийг засаж эсвэл дахин бичнэ. Өмнө хэлсний адилаар урт өгүүлбэрээс аль болох зайлсхий. Бичихээсээ өмнө яаж бичвэл зүгээр вэ гэсэн тойм, төлөвлөгөө гарга. Нэг догол мөр нэг л гол санаатай байх ёстой хоёр өөр утга, санаа хамтатгаж болохгүй гэдгээ сана. Мэдээж дэвшүүлсэн санаагаа баримтаар батлахгүй бол таны бичсэн зүйл үнэ цэнгүй, таны хувийн бодол болж хувирна. Хэт ерөнхийлж бичихээс зайлсхийх хэрэгтэй. Бичих арга барил, хэв маяг нь салбар, эсвэл

сэтгүүлээсээ хамаарч өөр өөр байна. Тиймээс нийгмийн ухааны бүх салбар нэг адил бичлэгийн хэв маягтай эсвэл адил эшлэл зүүлтийн стандарттай, үгийн тоотой биш юм. Жишээ нь, антропологийн ухааны эрдэм шинжилгээний бичлэг нь социологи, улс төрийн шинжлэх ухааны академик бичлэгээс их өөр. Илүү өөрөө судалгаандаа оролцож, ажиглаж олж авсан мэдлэгээ анхдагч эх сурвалж гэж үзэн ашиглахыг чухалчилдаг. Магадгүй та антропологийн судалгаа уншиж байсан бол "би нэг өдөр тийм хүнтэй уулзаад, тэгсэн чинь надад тэр зүйлийн талаар тэгж яриад нь өнөөх яриад байгаа зүйлтэй маань ингэж холбогдоод" гэх мэт, магадгүй зарим нийгмийн ухааны судлаачийн бодлоор "баримт бус, хувийнхаа үзэл бодлыг" яриад байгаа мэт санагдаж болно. Гэтэл антропологийн ухааны хэв маяг, тогтсон академик бичлэгийн үүднээс энэ байдал зохистой бичлэгийн хэв маяг юм.

**Сэдэвтэй холбоотой унших бүтээл**

Strunk Jr, W., & White, E. B. 2007. The Elements of Style Illustrated. Penguin.

Sword, Helen. 2012. Stylish Academic Writing. Cambridge: Harvard University Press.

Wallwork, A. and A. Southern. 2020. 100 Tips to Avoid Mistakes in Academic Writing and Presenting. London: Springer.

# БҮЛЭГ 11:

# СУДАЛГААГАА ХЭВЛҮҮЛЭХ СЭТГҮҮЛЭЭ ЯАЖ СОНГОХ ВЭ?

ТРОЙ СТЕРНБЕРГ

## Хичээлийн тухай

Судалгааны ажлаа бичиж эхлэх үедээ хэвлэн нийтлүүлэх сэтгүүлээ сонгосон байх хэрэгтэй байдаг. 2-3 сэтгүүлийг онилж, тэдгээрийн вебсайт дээрх зохиогч нарт зориулсан хэсгийг сайтар уншиж танилцах хэрэгтэй. Учир нь, сэтгүүл болгон өгүүллийн үгийн тоо, формат, эшлэлийн загвар зэргийн талаар өөрийн гэсэн онцгой шаардлагуудтай байдаг. Сэтгүүл сонгоход гол асуудал нь өгүүлэл болон сэтгүүлийн чиглэл салбар нийцэх эсэх юм. Сэтгүүлийн мөн чанар, зорилгод нийцэхгүй гэдэг шалтгаанаар маш олон өгүүлэл шууд буцаагддаг. Тиймээс бид энэ хичээлээр сэтгүүлээ сонгохдоо анхаарах гол зүйлийг анхааралтай авч үзнэ. Мөн нээлттэй буюу үнэгүй уншиж болохоор хэвлэдэг сэтгүүлийн талаар ярилцана.

## Өгүүллээ хэвлүүлэх сэтгүүлийг хэрхэн сонгох вэ?

Таны өгүүлэл хэвлүүлэхэд бэлэн үү? Бичсэн ажил чинь тодорхой сэдвийн талаар ойлголт, мэдлэг, задлан шинжилгээнд хувь нэмэр оруулж чадаж байна уу? Уншигч чинь хэн бэ гэдгээ тодорхойлсон уу? Бичвэрээ засаж, дахин шалгаж уншсан уу? Эх сурвалжаа зүй зохистойгоор дурдаж эшилсэн үү? Дээрх асуултуудад тийм гэж хариулж буй бол таны өгүүлэл хэвлүүлэхэд бэлэн болсон бололтой. Гэхдээ хаана хэвлүүлэх талбараа сонгосон уу? Блог, сэтгүүлийн нийтлэл, номын бүлэг, эрдэм шинжилгээний сэтгүүлийн тусгай дугаарт уу, бүүр эрдэм шинжилгээний бие даасан өгүүлэл үү, номын шүүмж үү. Энэ бүхнээсээ хамаарч таны бичлэгийн хэв маяг өөр байх ёстойг өмнөх бүлэгт тайлбарласан байгааг санаж буй биз ээ.

Stephen Lezak: academic article and publication for High Country News magazine


land

MDPI

Article

**Re-Placing the Desert in the Conservation Landscape: Charisma and Absence in the Gobi Desert**

Stephen Lezak

School of Geography and the Environment, University of Oxford, South Parks Road, Oxford OX1 3QY, UK; stephen.lezak@gmail.com

Received: 1 December 2018; Accepted: 28 December 2018; Published: 29 December 2018

check for updates

**Abstract:** Across the Gobi Desert in China and Mongolia, millions of newly planted trees struggle to survive amid adverse ecological conditions. They were planted by a wide variety of actors in an attempt to protect, restore, or modify the local environment, despite evidence of their negative consequences upon local ecosystems. This paper investigates how these afforestation projects both challenge and affirm recent theoretical work on conservation, while also providing key insights into the decision-making framework of land management across the world's third largest desert region. This analysis, supported by evidence from corporate practice, government policy, and participant observation, builds primarily on the work of Jamie Lorimer and other authors who identify the charisma of certain species as a primary driver of contemporary conservation. But the case of afforestation in the Gobi is inadequately explained by a desire to protect individual species; rather, I show how the charisma at the level of the landscape influences conservation practice. I extend this analysis to suggest that the management of deserts worldwide may be mediated by their perception as absent or empty spaces, thus explaining projects like afforestation which seem to re-place rather than conserve. Using the framework of absence and presence to better understand land use and environmental governance could have implications extending well beyond the Gobi Desert.

**Keywords:** absence; afforestation; charisma; China; conservation; desertification; Gobi; Mongolia


MENU HighCountryNews

SUBSCRIBE | THE MAGAZINE | DONATE NOW

WILDLIFE

**Wild horses, buffalo and the politics of belonging**

*On the Wind River Indian Reservation, two animals slip between the cracks of what is wild and what isn't.*

Stephen Lezak

Dec. 1, 2021 | From the print edition

A couple of years ago, Patti Baldes' phone rang. "Patti? The buffalo are out," said someone from the Wind River Reservation's Tribal Fish and Game Office. "Are they yours or are they Jason's?"

**Сэтгүүлээ яаж олох вэ?** Хамгийн энгийн арга бол хэвлүүлэхээр бичсэн өгүүллийнхээ ашигласан материалынхаа жагсаалтыг хар. Та өөрөөр ямар ямар сэтгүүлд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл ашиглаж наад өгүүллээ бичсэн байна вэ? Мөн томоохон хэвлэлийн компаниудын мэдээллийн сангаас хайж болно. Жишээ нь, Elsevier's компанийн Journal Finder Tool: https://journalfinder.elsevier.com/ сайтыг ашиглан тус компанийн хэвлэдэг сэтгүүлээс өөр тохирохыг олж болно. Нээлттэй буюу үнэгүй уншиж болохоор өгүүллийг чинь хэвлэх боломжтой сэтгүүл олмоор байвал Directory of Open Access Journals буюу https://doaj.org/ сайт руу орж хайгаарай. Мөн эрдэм шинжилгээний нийгэмлэг, холбооны сайтуудыг шалгаж үзээрэй. Жишээ нь, Ази судлалын нийгэмлэгийн Journal of Asian Studies сэтгүүл Азитай холбоотой олон сэдвээр өгүүлэл хэвлэдэг сайн сэтгүүл. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн Nomadic Studies сэтгүүл байж болно. Эзэн хааны антропологийн хүрээлэнгийн Journal of the Royal Anthropological Institute сэтгүүл мөн болно. Чухал дүрэм нь өгүүллээ нэгэн зэрэг олон сэтгүүлд илгээж болохгүйг анхаараарай. Өгүүлэл тань сэтгүүлийн хамрах хүрээ, зорилгод тодорхой нийцсэн байх ёстой. Уншигч чинь хэн бэ гэдгээ байнга бодож байх хэрэгтэй. Учир нь, та зөвхөн өөрийнхөө бүтээлийг жагсаалтыг нэмэх гэж өгүүлэл хэвлүүлээгүй. Та шинжлэх ухаанд хувь нэмэр болох уншигчид хэрэгтэй зүйл хэвлүүлэх гэж байгаа судлаач хүн. Жишээ нь, доор сэтгүүлийн сонирхол, зорилго ямар ялгаатай байж болохыг харуулж байна.

| **Central Asian Survey** | **Annals of the American Association of Geographers** |
|---|---|
| Нарийн салбарын – Төв Азийн судлаачид голдуу хэвлүүлдэг | Өргөн салбарын – хүний болон физик газар зүй |
| Бүс нутаг судлал - Төв Азийн жишээг сонирхоно | Дэлхий дахины жишээ сонирхдог |
| Төв Азийг судалсан олон янзын салбарын судалгааг хэвлэх сонирхолтой | Тус салбарын онолд хувь нэмэр оруулсан, шинэлэг санааг чухалчилдаг |

Харин доорх хүснэгтэд дээрх хоёр сэтгүүлд илгээсэн өгүүллийг хэн хянан нягталж, санал зөвлөж, сайжруулах санал гаргадаг болон хэвлэх эсэхийг шийддэг вэ гэдгийг харуулсан байна. Хэрвээ өгүүлэл

тань монгол тухай илүү өгүүлж буй бол тухайн бүс нутгийг хамарсан сэтгүүлд илгээх нь хэвлэгдэх магадлалыг нэмнэ.

| **Central Asian Survey** | **Annals of the American Association of Geographers** |
|---|---|
| Тухайн бүс нутгийн түүх, контекстийг маш сайн мэддэг судлаач | Хүн ба физик газар зүйн орчин цагийн концепцийн асуудлуудыг сайн мэддэг судлаач |

**Сэтгүүлийн импакт фактор гэж юу вэ?** Сэтгүүлийн нөлөөллийг тооцоолох арга юм. Анхдан Южин Гарфийлд санаачлан хөгжүүлсэн бөгөөд Clarivate компанийн Journal Citation Reports-ийн мэдээллийн сан дээр үндэслэсэн байна. Оксфордын их сургуулийн Бодлеайн номын сангийн гарын авлагад бичсэнээр бол "импакт факторыг өмнөх жилд тус өгүүлэл Journal Citation Reports-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэлд эшлэгдсэн тоог, сүүлийн 2 жилд тухайн сэтгүүлд нийтэлсэн өгүүллийн тоонд хувааснаар тооцож гаргадаг"[1] гэнэ. **Импакт фактор чухал уу?** гэвэл нөхцөл байдлаас хамаарч тийм бас үгүй гэж хариулж болно. Зарим сэтгүүл импакт фактортой болоход хэт жижиг байдаг. Гэвч тун чухал судалгаа хэвлэсэн байх нь бий. Мөн зарим сэтгүүл нь тухайн салбартаа нэр хүндтэй байдаг ч багахан импакт фактортой байдаг. Ялангуяа нийгэм-хүмүүнлэгийн ухааны сэтгүүлүүд иймбайх бий. Учир нь, байгалийн ухаанд хэвлэгдэж байгаа судалгаа тооны хувьд ч, эшлэлийн хувьд ч нийгэм-хүмүүнлэгийн ухаанаас их байдаг. 2021 оны байдлаар антропологийн ухааны хамгийн нэр хүндтэй сэтгүүлд болох American Anthropologists сэтгүүлийн импакт фактор 1.4, Current Anthropology сэтгүүлийнх 2,9 байна. Гэвч антропологич хүн эдгээр сэтгүүлд байнга өгүүлэл хэвлүүлээд байж чаддаггүй. Эдгээр сэтгүүлд хэвлүүлнэ гэдэг мэргэжлийн нэр төрийн хэрэг байдаг.

Нээлттэй (open access) буюу судалгаагаа үнэгүй уншихаар хэвлүүлэх боломж судлаачдад байдаг тухай өмнө дурдсан. Сүүлийн үед судалгааны санхүүжүүлэгчид эрдэм шинжилгээний өгүүллийг нээлттэй байдлаар хэвлэхийг шаардах болсон. Гэвч нэрд хүндтэй, импакт фактор өндөртэй сэтгүүлд нээлттэйгээр өгүүлэл хэвлүүлэх нь өндөр төлбөртэй байдаг. Учир нь, тухайн хэвлэх компани, сэтгүүл тухайн өгүүллийг худалдаж ашиг олж байгаа. Тийм байтал нээлттэй,

[1] https://libguides.bodleian.ox.ac.uk/c.php?g=422992&p=2890486

үнэгүй уншихаар хэвлэх нь өнөөх олж болох байсан ашгийг яах вэ гэдэг асуудал үүсгэх тул тухайн ашгийг урьдчилан төлж байгаа гэсэн санаа юм. Гэвч ямар нэгэн хэвлэх төлбөр авалгүйгээр таны өгүүллийг хэвлэдэг сэтгүүл бий. Өмнө дурдсанчлан Directory of Open Access Journals буюу https://doaj.org/ сайтаас тийм төрлийн сэтгүүлийг хайж олох боломжтой. Эдгээр сэтгүүл зохих ёсны хөндлөнгийн үнэлгээ хийсний дараа таны өгүүллийг хэвлэдэг тул уг мэдээллийн санд бүртгэлтэй байгаа гэж болно.

Мөн өөр нэгэн практик зөвлөгөө бол та судалгааныхаа удирдагч багш, хамтрагч судлаач нараасаа зөвлөгөө авч ямар сэтгүүл өөрийн тань судалгаанд тохиромжтойг мэдэх боломжтой. Туршлагатай судлаач өөрийн биеэр туулсан, үзсэн харснаа тантай хуваалцвал та ихээхэн цаг хугацаа хэмнэх боломжтой боллоо гэсэн үг.

### Сэдэвтэй холбоотой унших бүтээл

Clark, T. et al. (2021) Bryman's Social Research Methods, 6th Edition. Oxford: Oxford University Press

Кдрулд, Markku. "A phenomenological view of pictures in teaching and a novel method for analysing them." Nordic Studies in Science Education 10.2 (2014): 231-242.

Law, John. 2004. After Method: Mess in Social Science Research.

Morus, Iwan Rhys. 2017. The Oxford Illustrated History of Science. Oxford: Oxford University Press.

Schillings, P., & van Wickeren, A. (2015). Towards a Material and Spatial History of Knowledge Production. An Introduction. Historical Social Research / Historische Sozialforschung, 40(1 (151), 203–218. http://www.jstor.org/stable/24583135

Vogel, Jakob. 2015. Stony Realms: Mineral Collections as Makers of Social, Cultural and Political Space

# БҮЛЭГ 12:

# МЭРГЭЖЛИЙН СУДЛААЧИЙН СИВИ БИЧИХ

АРИЕЛ АХЭРН,
Г.МӨНХ-ЭРДЭНЭ

## Хичээлийн тухай

Өнөө үед академик ажлын байр маш өрсөлдөөнтэй болсон. The Times Higher Education-ий 2020 оны мэдээллээр бол PhD зэрэг хамгаалсан хүмүүсийн 70% нь салбараа 3,5 жилийн дотор орхисон байна. Эрдэм шинжилгээний байгууллагаас гадна судалгаа хийх боломжтой ажлын байр олон бий хэдий ч олон улсад өөрийгөө танилцуулж, харилцаа холбоо тогтоож, бичсэн бүтээлээрээ танигдахын тулд академик профайл бүрдүүлэх нь нэн чухал. Энэ хичээлээр бид цахим хэрэгслийг ашиглан олон улсын судалгааны профайлаа хэрхэн сайжруулж болох талаар, мөн өөрийн судалгааны бүтээлийг хэрхэн сурталчлах талаар үзнэ.

## Судлаачдад зориулсан платформууд

Судлаачид мэргэжил нэгт нөхөдтэйгээ хамтран судалгааны төсөл хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний бүтээлч үр дүнд хүрэхийг хүсдэг. Тиймээс судлаач болохыг хүсэж буй хэн нэгэн өөрийн мэргэжлийн намтар, дүр төрхөө мэргэжлийн түвшинд бүрдүүлэх хэрэгтэй. Энэ ажил СиВи (CV)-гээ яаж бичихээс эхэлнэ. Та мэргэжлийн ажил хийх гэж байгаа тул тэрхүү мэргэжилтэйгээ холбоотой туршлага, дадал, амжилтаа л СиВи-дээ дурдах хэрэгтэй. Хэт хувийн мэдээлэл, сайн мэргэжилтэн гэдгийг чинь харуулахгүй жишээ баримт, мэдээллийг багтаах хэрэггүй.

Мэргэжлийн мэдээлэл гэдэгт та ямар судалгаа хийж байсан, ямар хуралд илтгэл хэлэлцүүлж байсан, ямар судалгааны төсөл, мэргэжлийн ажилд ажиллаж байсан ялангуяа ямар ямар судалгаа хэвлүүлж байсан тухай бүтээлийн жагсаалт зэрэг мэдээлэл орно. Мөн та мэргэжлийн судлаач болохын хүсэж буй бол аль болох тэр сонирхолтой чинь холбоотой ажил олж хийх хэрэгтэй. Судалгааны туслах, орчуулагч, судалгааны нарийн бичиг, лабораторын туслах, эрдэм шинжилгээний ажилтан гэх мэт ажил дээрхэд орно.

Та СиВи-гээ бэлдэхдээ бүрэн болон тойм гэсэн маягтай хоёр хэлбэрээр бэлдвэл зүгээр. Тойм эсвэл товч гэж хэлж болохоор СиВи тань 2 нүүр хуудаснаас хэтрэхгүй, таны талаар товч тодорхой ойлголт өгөхүйц байна. Харин дэлгэрэнгүй хувилбар дээрээ мэргэжлийн бүх мэдээллээ багтааж болно. Ерөнхийдөө СиВи-д юу юуны талаарх мэдээлэл багтаж болох вэ гэдгийг доор хүснэгтээр харууллаа.

| Агуулга | Тайлбар |
|---|---|
| Хувийн мэдээлэл | Нэр, хаяг, и-мэйл хаяг, вебсайт |
| Мэргэжлийн туршлага | 5-7 өгүүлбэрээр өөрийн мэргэжлийн туршлагыг талаар бичнэ. Энд та өөрийн ажил эрхлэлтийн байдлыг багтааж болно. |
| Боловсрол | Өөрийн боловсрол эзэмшсэн байдлыг он дараалын дагуу жагсаана |
| Бүтээлийн жагсаалт | Өөрийн хэвлүүлсэн судалгааг он дараалын дагуу жагсаана |
| Судалгаа | Хэрэгжүүлсэн, ажиллаж байсан судалгааныхаа төслийг жагсаана |
| Тэтгэлэг, судалгааны санхүүжилт | Шалгарч байсан тэтгэлэг, шагнал, судалгааны санхүүжилтээ бичнэ |
| Багшлах туршлага | Хэрвээ их сургуульд хичээл зааж байсан бол тэр туршлага, зааж байсан хичээлийнхээ жагсаалтыг бичнэ |
| Мэргэжлийн туршлага | Мэргэжилтэй тань холбоотой өөр туршлагаа бичнэ. Жишээ нь, зөвлөх үйлчилгээний туршлага г.м |
| Мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл | Мэргэжлийн холбооны гишүүнчлэлтэй бол тэр бүхнээ энд бичнэ |
| Гадаад хэлний чадвар | Сонголтоор, зайлшгүй гэж үзвэл ямар ямар гадаад хэлний чадвартайгаа бичиж болно |

Мэргэжил нэгтэй судлаачидтай танилцах, танилын хүрээгээ тэлэх өөр нэг арга бол интернетэд байх мэргэжлийн сүлжээд юм. Жишээ нь, Google Scholar, OrcidID, LinkedIn, ResearchGate, Academia.edu гэх мэт үйлчилгээг ашиглаж болно. Ялангуяа мэргэжлийн түвшинд LinkedIn ихээхэн нөлөөтэй байдаг. Тиймээс та заавал LinkedIn-д хаяг нээгээрэй. Эдгээр үйлчилгээнд хаягтай болсноор та зөвхөн мэргэжил нэгтэнтэйгээ танилцахаас гадна бусдын судалгааг үнэгүй унших боломжтой. Учир нь, ихэнх судлаачид өөрсдийн хэвлүүлсэн судалгааг дээрхийн мэт хаяг дээрээ үнэгүй байршуулсан байдаг талтай.

Энэ маягаар судлаачид бусад судлаачтайгаа танилцан хамтран ажиллаж, мэргэжлийн бүтээлч үр дүнд хүрдэг. Мөн та нийгмийн

сүлжээгээ ч ашиглаж бусад судлаачтай танилцан, олон сайхан боломж өөртөө нээх нь нээлттэй. Нийгмийн сүлжээний зорилго чинь хүмүүстэй холбогдох биш үү? Заримдаа тэр зорилгынх нь дагуу ашиглаж бай. Тиймээс аль болох идэвхитэй бай, сониуч бай, олон төрлийн нийгмийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог байх хэрэгтэй.

